



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2018 • X • № 24

**"АЛТНЫ ФОРУМ"
ГАДААД
ВАЛЮТЫН
УЛСЫН НӨӨЦИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХЭД
ЧИГЛЭСЭН
АСУУДЛУУДЫГ
ХӨНДӨВ**

**Э.АНАР:
ФИНТЕКИЙН
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИЖ, БЭЛЭН
БУС ТӨЛБӨРИЙН
ХЭРЭГСЛИЙН
ХЭРЭГЛЭЭГ
НЭМЭГДҮҮЛНЭ**

МОНГОЛ УЛСЫН ЭРДЭНЭСИЙН САНГААС: VIII БОГД ЖАВЗАНДАМБА ХУТАГТЫН ЭРИХ



Mongolbank.mn



@mongolbank_mn



www.mongolbank.mn



Mongolbankmn

“АЛТНЫ ФОРУМ” ГАДААД ВАЛЮТЫН УЛСЫН НӨӨЦИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН АСУУДЛУУДЫГ ХӨНДӨВ

Алтны салбарын үр өгөөжийг нэмэгдүүлэх, тулгамдаж буй бэрхшээлийг шийдвэрлэх, эрх зүйн тогтвортой байдлыг бий болгох зэрэг асуудлаар бодлого боловсруулагчдыг нэг дор цуглуулсан “Алтны форум” 10 дугаар сарын 2-ны өдөр болсон юм. Форумыг “Блүүмбэрг ТВ Монголиа”-аас зохион байгуулж, УУХҮЯ, БОАЖЯ Монголбанк, Монголын алт үйлдвэрлэгчдийн холбоо, төрийн холбогдох агентлагууд, судлаач, эдийн засагчдын төлөөлөл оролцлоо.

Энэ үеэр яригдсан гол асуудал бол эх орныхоо алтыг төв банкинд тушаах таатай нөхцөлийг үргэлжлүүлэхийн тулд юун түрүүнд 2019 оны нэгдүгээр сарын 1-нээс дуусгавар болж буй Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг бууруулах тухай хууль буюу АМНАТ-ийн 2.5 хувийн татварын үйлчлэх хугацааг дахин сунгах тухай асуудлыг дэвшүүлээ. Монголбанкнаас энэхүү асуудалд эртнээс анхаарал хандуулж, 2020 он хүртэл сунгах саналыг холбогдох яамдад хүргүүлээд байгаа тухай энэ үеэр мэдээлж байлаа. Үүнээс гадна алтны салбарт алт олборлолтыг албажуулснаар байгаль орчны сөрөг нөлөөллийг багасгах, хариуцлагатай уул уурхайн зарчим бүрэн мөрдөгдөх тул зохицуулалтын эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай тухай олон санал гаргаж байлаа.

“Алтны форум”-ын үеэр оролцогчид салбарын асуудлаар хэрхэн байр сууриа илэрхийлснийг хүргэе.



**УУХҮ-ИЙН САЙД
Д.СУМЬЯАБАЗАР:**

Уул уурхайн салбарыг олон тулгууртай болгох зорилтын хүрээнд алтны салбарыг жил бүр тэрбум давсан америк долларын орлого бүрдүүлдэг салбар болгож, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилт 2030-д хүрэх нэг тулгуур болгон хөгжүүлнэ. Байгаль орчин, нөхөн сэргээлт 2000 оны дунд үеэс эхлэн салбарын тэргүүлэх компаниудын хүчин чармайлт, талуудын хамтын ажиллагааны үр дүнд тодорхой ахиц гарсан. Алт олборлогчдын тушаасан грам алт бүр монгол гэр бүлүүдийн идэх ширхэг талх бүрийн үнийг бага ч гэсэн хямдруулж, таны өнөөдөр ургамалжуулсан шоо дөрвөлжин газар бүр уул уурхайд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлнэ. Та бүхнийг эх оронч байж, Монгол банкиндаа алтаа тушааж, олборлолтоо тогтвортой хадгалж ажиллахыг уриалж байна.





УУХУЯ-НЫ ГЕОЛОГИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА Б.МӨНХТӨР:

Алт олборлох ААН бүх бичиг баримтаа бүрдүүлээд ажлаа эхлүүлэхээр орон нутагт очоод нутгийн захиргаа болон иргэдтэй ойлголцоход ихээхэн хүндрэл үүсдэг хэвээр байна. ААН төлөвлөгөөгөө батлуулаад очсон тул олборлолтоо эхлүүлэх гэхээр иргэний нийгмийн байгууллагууд эсэргүүцдэг, жагсаал зохион байгуулдаг байна. 2019 оны төсвийн тухай хуульд татварын орлогын тодорхой хувийг орон нутагт хуваарилахаар тусгасан нь үйлдвэрлэгчдэд томоохон дэмжлэг болж, орон нутгаас ирэх эсэргүүцлийг бууруулах хөшүүрэг болно гэж бодлого боловсруулагчид үзэж байна. Хууль бус олборлолт, нөхөн сэргээлт нэрээр олборлолт явуулах нь энэ салбарын толгойн өвчин боллоо.



МОНГОЛБАНКНЫ НУСЗЗГ-ЫН ЗАХИРАЛ А.ЭНХЖИН:

Гэнэтийн ашгийн 68 хувийн татвар ногдуулсны дараа алт худалдан авалт 2 тонн болж буурсан түүхтэй. Харамсалтай нь энэ үед гадаад зах зээлд алтны үнэ маш өндөр буюу таатай байсан. Хууль эрх зүйн нөлөө эдийн засагт хэрхэн муугаар тусдагийг эндээс харж болно. Харин сүүлийн жилүүдэд алт худалдан авалт эргээд өслөө. АМНАТ-ийг 2.5 хувь болгон бууруулсан нь гол хүчин зүйл болсон. Мөн иргэдийн алт тушаах хэмжээ 2014 оноос өсч, нийт алт тушаалтын 63 хувийг эзэлсэн нь ААН-үүд татвараас зайлсхийж байгаатай холбоотой. Татварын орчныг боловсронгуй болгосноор энэ асуудлыг шийдэх боломжтой.



АЛТ ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.БАДАРЧ:

Хэдийгээр алт тушаалт өсч байгаа ч хууль эрхзүйн орчин тогтворгүй хэвээр байна. Хайгуулыг зогсоосноор алт олборлогчдын ирээдүй бүрхэг боллоо. Нэгэнт хөрөнгөө оруулчихсан ААН-үүд цаашид хэрхэхээ мэдэхгүй байна. Мөн хайгуулын тусгай зөвшөөрлийг мэргэжлийн бус байгууллагад олгосноор энэ салбарын нэр хүнд унаж, тусгай зөвшөөрөл арилжааны хэрэгсэл болж хувирсан. Тусгай зөвшөөрлийг тогтвортой ажилласан туршлагатай, хариуцлагатай уул уурхай эрхэлсэн үү гэх мэтээр тухайн ААН-ийн өмнөх түүхийг харгалзан олгох ёстой. Түүнчлэн тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгоход гаднын томоохон хөрөнгө оруулалттай ААН-үүд давуу байдлаа ашиглан шалгардаг. Харин дотоодын ААН-үүд авч чадахгүй байна. Иймд дотоодын ААН-ийг дэмжинэ гэдэг эрх баригчдын амлалт хий хоосон уриа болж үлдэж байна.



Онцлох үйл явдал

ХУУДАС

Цахим эринд цахим төлбөр
тооцоо аян нээв

5

Ярилцлага:

ХУУДАС

Э.Анар: Финтекийн хөгжлийг
дэмжиж, бэлэн бус төлбөрийн
хэрэгслийн хэрэглээг
нэмэгдүүлнэ

7

Байр суурь:

ХУУДАС

ОУВС, Дэлхийн банкны удирдах
зөвлөлийн намрын ээлжит
намрын чуулга уулзалт

10

Асуулт, хариулт:

ХУУДАС

Монголбанкны хэвлэлийн бага
хурлаас 2018.10.24

12

**Мөнгөн тэмдэгтийн
түүх:**

ХУУДАС

1966-1983 оны мөнгөн тэмдэгт

16

**Улаанбаатарын
зөвшилцөл:**

ХУУДАС

Байгалийн баялагаа оновчтой
байдлаар эдийн засгийн эргэлтэнд
оруулах, баялагийн өгөөжийг
хүртэх, хүртээмжтэй өсөлтийн бий
болгохын тулд

18

**Монголбанк юу хийдэг
вэ?**

ХУУДАС

А.Батсайхан: Цахим мөнгөний
хэрэглэгч болсноор цаг хугацаа,
зардлаа хэмнэх боломжтой

22

Орон нутаг:

ХУУДАС

Эх орныхоо алтыг Эрдэнэсийн
сандаа

25

Судалгаа:

ХУУДАС

Жижиг дунд үйлдвэрлэлийн
хөгжил, санхүүжилтийн байдал

28

Ярилцлага:

ХУУДАС

Ш.Алтанцэцэг: Ханш суларлаа,
ханшаа алдлаа гэж зарим нь
шүүмжилж байгаа ч тийм биш

32

Дэлхийн эдийн засаг:

ХУУДАС

Эдийн засгийн тогтвортой өсөлтөд
технологи болон уур амьсгалын
нөлөө 35

35

Санхүүгийн боловсрол:

ХУУДАС

Ирээдүйдээ зориулж
хуримтлуулах нь

37

Журмын төсөлд санал авч эхлэв

2018.10.02



“Банкны барьцаа хөрөнгийн үнэлгээний журам”-ын төсөлд олон нийтийн саналыг авч эхэллээ. Уг журмын зорилго нь банкуудыг барьцаа хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаандаа баримтлах нэгдсэн зарчим, шаардлагыг тодорхойлоход оршжээ. Банкууд барьцаа хөрөнгийн мэргэшсэн үнэлгээг Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын стандартад нийцүүлэн гүйцэтгэх өөрсдийн журам, бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөх эрх зүйн орчинг энэ журмаар бүрдүүлэх юм. Иймд Монголбанкнаас Банкны барьцаа хөрөнгийн үнэлгээний журмын төслийг боловсруулахын тулд Захиргааны ерөнхий хуулийн дагуу олон нийтээс санал авах зорилгоор танилцуулж эхлээд байгаа юм.

Цахим эринд цахим төлбөр тооцоо аян эхэллээ

2018.10.10

“Цахим эринд-цахим төлбөр тооцоо” аяныг 2018 оны 10 дугаар сарын 10-наас 12 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл зохион байгуулахаар боллоо. Энэхүү аяны хүрээнд төлбөрийн системийн талаар Монголбанкнаас баримталж буй бодлого, эрх зүйн зохицуулалт, финтекийн хөгжлийг дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, цахим эринд цахим төлбөр тооцоог хурдан шуурхай гүйцэтгэх дэвшилтэт шийдэл зэргийг нийтэд үнэн зөв мэдээлэх, таниулан сурталчлах, соён гэгээрүүлэхэд чиглэсэн ажлыг хийхээр төлөвлөжээ. Тиймээс цахим төлбөр тооцооны хөгжлийг дэмжих, нийтийн хэрэглээ болгож хэвшүүлэх, түүний давуу тал, эдийн засгийн үр өгөөжтэй холбоотой сэдвээр сургалт, хэлэлцүүлэг зэрэг үйл ажиллагааг зохион байгуулна.



Мөнгөний бодлогын баримт бичгийн төслийг олон нийтэд нээлттэй таницуулав

2018.10.11



Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг олон нийтэд хоёр дахь жилдээ нээлттэй танилцуулж, хэлэлцүүлээ. Энэ үеэр Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч О.Эрдэмбилэг уг бодлогын баримт бичгийн зорилтын үндсэн агуулгыг тайлбарласан юм. Мөн “Макро эдийн засгийн төлөв байдал, эдийн засагт бий болсон эерэг өөрчлөлтүүд болон цаашдын сорилт”, “Мөнгөний бодлогын 2019 оны Үндсэн чиглэл” гэсэн сэдвээр тус тус танилцуулга хийв. Ирэх жил баримтлах мөнгөний бодлого нь эдийн засгийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн сэргэлтийг бэхжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн болон тогтвортой санхүүжилтийн сайн туршлагыг нэмэгдүүлэхэд анхаарчээ. Мөн санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудлыг анх удаа тусгасан нь санхүүгийн зах зээлийн хөгжлийг гүнзгийрүүлж, эдийн засгийн өсөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэх ач холбогдолтойг тайлбарлалаа.

Тоон гарын үсгийг цахим төлбөр тооцоонд нэвтрүүлээ

2018.10.10

Азийн Хөгжлийн Банкны зээлийн санхүүжилтээр “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийг хэрэгжүүлснээр төлбөрийн ₮ картыг EMV/NFC чип технологид шилжүүлэх, автомат клирингийн системийг нэвтрүүлэх, санхүүгийн байгууллагад ашиглах тоон гарын үсгийн системийг Монгол Улсад нэвтрүүлэх зэрэг ажлыг эхлүүлээд байна. Цахим гарын үсгийн системийг Монголбанкны дотоод болон төлбөр тооцооны бүх систем, банк, банк бус санхүүгийн байгууллагын Монголбанк руу хандаж буй зээлийн мэдээллийн сан, Төв банкны үнэт цаас болон валютын арилжааг гүйцэтгэх банк хоорондын цахим арилжааны гэх мэт системүүдэд нэвтрүүлэх ажлыг эхлүүлж байна. Цаашид энэхүү дэд бүтцийг ашиглан, банк, санхүүгийн байгууллагууд нэмэлт өндөр хэмжээний хөрөнгө оруулалт хийхгүйгээр дотоод системдээ шууд ашиглах боломжтой болно.



Эдийн засгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд бодлогоор дэмжихийг зөвлөв

2018.10.12



Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал болж, төлбөрийн тэнцэл, гадаадын хөрөнгийн байршил, гадаад өрийн өнөөгийн байдлыг авч хэлэлцлээ. Үүнээс экспортын үйлдвэрлэл, үйлчилгээ дэх Монголоос гаралтай хүчин зүйлс, ханган нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, гадаадын зээл хөрөнгө оруулалтыг үндэсний үйлдвэрлэл, суурь дэд бүтэц, ажлын байрны тоог олшруулахад бодлогоор чиглүүлэх нь зүйтэй гэж үзэв. Мөн Монголбанкнаас нэгтгэн өөрийн вэб хуудсанд нээлттэй мэдээлж буй төлбөрийн тэнцэл, хөрөнгө оруулалт, гадаад өрийн тайлан мэдээлэл нь олон улсын жишиг стандартад нийцсэн, бодлого боловсруулагчид, судлаачид, багш оюутан нарын гарын авлага болдгийг онцлон тэмдэглэж, жирийн иргэдэд илүү ойлгомжтой болгох талаас анхаарахыг зөвлөлөө.

Дэлхийн хуримтлалын өдрийг хоёр дахь жилдээ тэмдэглэв

2018.10.22

“Дэлхийн хуримтлалын өдөр”-өөр Хуримтлалын аян зохион байгуулж хуримтлалын ач холбогдол, өрхийн төсөв, түүнийг удирдах арга зүйн талаар оролцогчдод мэдээлэл өглөө. Энэхүү тэмдэглэлт өдөрт дэлхийн 140 гаруй улс орон ач холбогдол өгч, ёслол төгөлдөр тэмдэглэдэг уламжлалтай бөгөөд Монголбанк, Монголын Банкны Холбоо, ХБНГУ-ын Хадгаламжийн банкны Олон улсын хамтын ажиллагааны сан, Хадгаламжийн Даатгалын Корпораци хамтран 2017 онд анх өөрийн улсдаа нэвтрүүлжээ.



Э.АНАР: ФИНТЕКИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИЖ, БЭЛЭН БУС ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ХЭРЭГЛЭЭГ НЭМЭГДҮҮЛНЭ

Монголбаннаас “Цахим эринд Цахим төлбөр тооцоо” аяныг хэрэгжүүлж эхлээд байгаатай холбогдуулж, Монголбанкны Төлбөр тооцооны газрын захирал Э.Анартай цахим төлбөр тооцоотой холбоотой зарим асуудлаар ярилцлаа.



Юуны өмнө аян зохион байгуулах болсон тухай мэдээлэл өгнө үү?

Өнөөдрийн цахим эрин зуунд техник технологийн дэвшлийг ашиглаж төлбөр тооцоог хурдан шуурхай, амар хялбар гүйцэтгэх шинэ боломж, шинэ хөгжил дэвшил нэвтэрсээр байна. Үүнтэй холбоотойгоор Монголбанкнаас төлбөрийн системийн талаар баримталж буй бодлого, үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги, шинээр хэрэгжиж эхлээд байгаа Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, төлбөрийн системийг хөгжүүлэх, шинэчлэх төслийн үйл ажиллагааг нийтэд үнэн зөв, ойлгомжтой байдлаар таниулан сурталчлах замаар иргэд, хэрэглэгчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд анхаарч энэхүү аяныг хэрэгжүүлэхээр санаачлан хэрэгжүүлж эхлээд байна.

Төлбөрийн системийг энгийн үгээр тайлбарлаж хэлбэл ямар

тодорхойлолт гарах вэ?

Төлбөрийн систем нь 4 зүйлийн нэгдэл юм. Үүнд иргэд, хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгийн шилжүүлгийг гүйцэтгэх зөвшөөрөл бүхий байгууллага, төлбөр тооцоог дамжуулах техник, технологийн дэд бүтэц, төлбөр хийхэд ашиглах төлбөрийн хэрэгсэл, эдгээрийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж байдаг.

Аливаа улс орны эдийн засаг, санхүүгийн системийн хөгжил, түүний тогтвортой байдлын нэг чухал хэмжүүр нь тухайн улсын үндэсний төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагаа юм. Хэрвээ төлбөрийн систем тасалдаж, найдваргүй ажиллавал банкууд мөнгө шилжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх боломжгүй болно.

Өөрөөр хэлбэл, иргэд, хэрэглэгчийн мөнгөн хөрөнгө төлбөрийн системээр дамжин өөр хоорондоо солилцоонд орж,

эдийн засагт эргэлдэж байдаг тул төлбөрийн систем нь эдийн засаг дахь хурдны зам юм. Өнөөдрийн байдлаар энэхүү зам нь мэдээллийн технологид суурилсан санхүүгийн сүлжээ болон хувьсан өөрчлөгджээ. Иймд энэхүү сүлжээг шинэчлэн хөгжүүлж, түүний найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах нь улс орныхоо эдийн засгийн хөгжлийг дэмжих, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад нэн чухал ач холбогдолтой юм.

Энэ аяны хүрээнд Монголбанкнаас авч хэрэгжүүлэхээр зорьж буй арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.

Аяны хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь Финтекийн хөгжлийг дэмжих, бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Төлбөрийн системийн эрх зүйн орчныг бэхжүүлэх ажлын хүрээнд Монголбанкнаас “Клирингийн систем ажиллуулах, төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл

ажиллагаа эрхлэх журам"-ыг батлан гаргана. Энэхүү журам гарснаар Монголбанкнаас зөвшөөрөл авсан хуулийн этгээд клирингийн үйл ажиллагаа, төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх боломжтой болно.

Нийтийн санхүүгийн боловсролыг дэмжих зорилгоор төлбөрийн системийн үйл ажиллагаа, эрх зүйн шинэ зохицуулалт, Монголбанкнаас баримтлах бодлогын талаар хэвлэмэл гарын авлага бэлтгэж нийтэд түгээнэ. Төлбөрийн системийн оролцогч, хэрэглэгчийн дунд хууль, эрх зүйн орчны шинэчлэлийн талаар уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулна.

Төлбөрийн системийн дэд бүтцийг шинэчлэх ажлын хүрээнд Монголбанкнаас Төлбөрийн системийн шинэчлэл төслийг хэрэгжүүлж байгаа. Аяны хугацаанд клирингийн системийг шинэчлэхтэй холбоотой сургалтыг төлбөрийн системийн оролцогч болон Финтек компаниудад зориулан зохион байгуулна.

Монголбанкнаас төлбөрийн хэрэгслийн нууцлал аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор төлбөрийн ₮ картыг EMV/NFC чип технологид шилжүүлэхийг зорьж байгаа бөгөөд энэ нь Финтекийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн нэлээд чухал алхам болно гэж үзэж байна.

Аяны хугацаанд олон нийтийг хамарсан өдөрлөгийг банк, Финтек компаниудтай хамтран зохион байгуулахаар төлөвлөж байна. Энэ нь иргэд, хэрэглэгч, төлбөрийн

үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон төлбөрийн системийг удирдан зохион байгуулах, хяналт тавих эрх бүхий этгээд бүгд нэгэн дор цугларч үзэл бодол, үйл ажиллагаа, дэвшилтэт технологийг хуваалцах, хамтран судалж, харилцан суралцах боломжийг олгоно гэж найдаж байна.

Аяны нээлтийн үеэр танилцуулсан санхүүгийн байгууллагад ашиглах тоон гарын үсгийн системийг нэвтрүүлэх зорилго, ач холбогдолын талаар тодруулж өгнө үү.

Энэ цахим эринд дэлхий нийтээр бэлэн бус төлбөр тооцоог дэмжиж, нийтийн хэрэглээ болгох зорилгоор цахим төлбөр рүү эрчтэй шилжиж байна. Санхүүгийн зах зээлд нэвтрээд байгаа мэдээллийн технологийн дэвшилтэт шийдлийг өдөр тутмын төлбөр тооцоондоо ашиглаж, цаг хугацааг хэмнэх, орон зайг товчлох шаардлага өнөөгийн бидний амьдралд зайлшгүй тулгарч байна. Иймд, банк, санхүүгийн үйлчилгээ авахын тулд заавал өөрийн биеэр очиж, гарын үсэг зурах эсвэл төлбөр тооцоогоо баталгаажуулах ажиллагааг халах үүднээс энэхүү системийг хөгжүүлэх ажлыг Монголбанкнаас санаачлан эхлүүлсэн. Өнөөдрийн байдлаар санхүүгийн байгууллагад ашиглагдах тоон гарын үсгийн системийг Монголбанкны дотоод системд туршиж байна. Цаашид энэхүү системийн хэрэглээг өргөжүүлж, Монголбанкны төлбөр тооцооны бүх систем, банк болон банк бус байгууллагын Монголбанк

руу хандаж буй зээлийн мэдээллийн сан, төвбанкны үнэт цаас болон валютын арилжааг гүйцэтгэх банк хоорондын цахим арилжааны системүүдэд нэвтрүүлэхийг зорьж байна.

Аяны үр дүнг хэрхэн хүлээж байна вэ?

Аяны үр дүнг нэг талаас иргэд, хэрэглэгч нь Монгол Улсын үндэсний төлбөрийн систем, финтекийн хөгжил, бэлэн бус төлбөрийн хэрэгсэл, цахим төлбөр тооцооны талаар нэгдсэн ойлголтод хүрэх, бэлэн бус төлбөр тооцоог нийтийн хэрэглээ болгож хэвшүүлэх, нөгөө талаас төлбөрийн системийн оролцогч хоорондын харилцан хамтын ажиллагааг дэмжих, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг болно гэж үзэж байна.

Аяны хүрээнд хийж байгаа ажлын талаар мэдээ мэдээллийг иргэд, олон нийт хэрхэн авах боломжтой вэ?

Аяны хүрээнд зохион байгуулж буй арга хэмжээ болон төлбөрийн системийн талаарх мэдээ мэдээлэл авах хүсэлтэй иргэд, хэрэглэгч, байгууллага санал хүсэлт, асуултаа Монголбанкны цахим хуудсаар болон нийтийн цахим сүлжээн дэх Монголбанкны facebook хаягаар хандан авч болно.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Финтек гэж юу вэ?



Финтект хамаарах ойлголтууд



Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлогын талаарх мэдээллийг дараах хаягаар авна уу.



www.mongolbank.mn



@mongolbank.mn



@mongolbank_mn



mongolbank



11-310119

**ОУВС, ДЭЛХИЙН
БАНКНЫ НАМРЫН
ЭЭЛЖИТ ЧУУЛГА
УУЛЗАЛТ 10-Р САРЫН
08–14 ӨДРҮҮДЭД
ИНДОНЕЗИ УЛСЫН
БАЛИ АРАЛД
БОЛЛОО. “ИРЭЭДҮЙН
ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН
ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ
БҮРДҮҮЛЭХИЙН
ТУЛД ӨНӨӨДРИЙН
ЗӨРЧИЛДӨӨНИЙГ
АРИЛГАХ НЬ” СЭДВИЙН
ДОР ОЛОН УЛСЫН
ХУДАЛДААНЫ
АСУУДЛУУД,
УЛС ОРНУУДЫН
ӨР, ЦААШДЫН
ХҮНДРЭЛҮҮД,
ФИНТЕК, ХҮМҮҮН
КАПИТАЛ БОЛОН
ТҮҮНД ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ,
ЭДИЙН ЗАСГИЙН
ХҮРТЭЭМЖТЭЙ
ӨСӨЛТИЙГ ХАНГАХ
ЗЭРЭГ АСУУДЛААР
ХЭЛЭЛЦЭВ.**

**ЭНЭ ҮЕЭР ХЭН ЮУ
ХЭЛСНИЙГ ОНЦОЛЖ
БАЙНА.**



**ОУВС-ИЙН
УДИРАХ ЗАХИРАЛ
КРИСТИН ЛАГАРД**

...олон улсын хамтын ажиллагааны тус дэмээр дэлхий санхүүгийн хямралаас гарч, эдийн засгийн өсөлттэй байна. Энэ хамтын ажиллагааг ASEAN-ий орнуудаас харж болно. Гэхдээ эдийн засгийн өсөлт бүс нутаг болон хүн амд төдий л хүртээмжтэй биш байна. Өнөөдөр дэлхийн эдийн засагт 2 хүндрэл тулгараад байна. Нэг дэх нь – Макро хүндрэл: Өнөөгийн худалдааны хурцадмал байдал нь дараагийн 2 жилийн хугацаанд дэлхийн ДНБ-ний өсөлтийг 1 орчим нэгж хувиар бууруулахаар байна. Мэдээж бид дэлхийн худалдааны тогтолцоог илүү сайн, шударга, чадавхитай болгох замаар худалдаанаас цөөн улс ашиг хүртэж, ихэнх улс алдагдал хүлээж буй хүндрэлийг шийдвэрлэх боломжтой. Өөрөөр хэлбэл тогтолцоог засахаас биш нурааж болохгүй. Нөгөө талаар улс орнуудын өрийн хэмжээ нэмэгдсээр байна. Сүүлийн тооцоогоор улс орнуудын болон хувийн секторын зээл 182 их наяд ам.долларт хүрч дэлхийн ДНБ-ний 224%-тай тэнцэж байна. Үүнээс гарах зам бол хамтын ажиллагаа бөгөөд энэ нь ОУВС-гийн үйл ажиллагааны суурь зарчим билээ. Хоёр дахь буюу XXI зууны хүндрэл болон Олон талт байдал: Тэгш бус байдал, технологи, тогтвортой байдлын хүрээнд эдийн засагт сүүлийн үед ихээхэн өөрчлөлт гарч байна.

Тогтвортой өндөр өсөлт нь тэгш бус байдал буурахад эерэг нөлөө үзүүлдэг болохыг ОУВС-гийн судалгаануудаас харж болно. Тэгш бус байдлыг арилгахад засгийн газар, хувийн сектор, иргэний нийгэмлэгүүдийн хамтын ажиллагаа чухал.

Технологийн хувьд дижитал хувьсгал сайн, муу олон үр дагаварт хүргэж байна. Финтек нь банкинд дансгүй 1.7 тэрбум хүнд санхүүгийн үйлчилгээг хүргэх хүртээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн нөөц бололцоог өсгөж байна. Гэхдээ санхүүгийн тогтвортой, аюулгүй байдлыг алдагдуулахгүйн тулд Финтекийг анхааралтай зохицуулах нь чухал. Тиймээс бид Дэлхийн банк болон бусад байгууллагуудтай хамтран “Балигийн Финтекийн хөтөлбөр”-ийг эхлүүлсэн.

Уур амьсгалын өөрчлөлт нь тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлж байгаа тул бид “Тогтвортой хөгжлийн зорилт” хэмээх өргөн хүрээний хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Тогтвортой гэдэг үгний ард мөн хамтын ажиллагаа явж байдаг бөгөөд хувийн сектор, донор, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа нь иргэдийн эрүүл мэнд, боловсрол, усны хүртээмж, дэд бүтэц гэх мэт ялгаатай байдлыг бууруулах боломжтой.



ДЭЛХИЙН БАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ
ЖИМ ЁН КИМ

Цунами дайрсан хүнд хэцүү цаг үед энэхүү томоохон чуулга уулзалтыг амжилттай зохион байгуулж байга Индонези Улсад талархлаа илэрхийлье. Дэлхийн банк, ОУВС-ын хавар, намрын чуулга уулзалтуудаар дэлхийн эдийн засгийн чухал асуудлуудаар хэлэлцдэг ч, бид ихэнхдээ богино хугацааны асуудлууд дээр төвлөрөх гээд байдаг сул талтай. Энэ удаагийн чуулга уулзалтаар бидний анхаарах ёстой, бүх улсад хамаатай урт хугацааны 2 чухал асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрх нь уур амьсгалын өөрчлөлт. Уур амьсгалын өөрчлөлт нь дэлхийн хөгжил, ядуурлыг бууруулах зэрэгт томоохон бэрхшээл болсоор байна. Дэлхийн дулаарал ялангуяа дэлхийн хамгийн ядуу, эмзэг иргэдэд сөргөөр нөлөөлж байна. Цаашид дулаарал явагдсаар байгаа тул бид цаг алдалгүй тэмцэх хэрэгтэй.

Хоёрдугаарх нь хүмүүн капитал буюу мэдлэг, чадвар, эрүүл мэнд зэрэгт анхаарал хандуулахыг шаардаж байна. Улс төрчид эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг сайжруулах зорилгоор багагүй хөрөнгө оруулалт хийдэг ч урт хугацаанд үр дүнд хүрэлгүй бодлого өөрчлөгдсөөр байдаг. Тиймээс бид улс орнуудыг иргэддээ хөрөнгө оруулалт хийж байгаа байдлыг хэмжих шинэ арга хэрэгсэл болох “Хүмүүн капиталын индекс”-ийг нэвтрүүлж байна. Энэ индекс бодлого боловсруулагч нарт хүүхдийн эрүүл мэнд, боловсролд анхаарснаар иргэдийн орлогыг нэмэгдүүлж улс орны хөгжлийг хурдасгах боломжтойг харуулах зорилготой.

Хэрэв бид яаралтай энэ хоёр чиглэлээр урт хугацааны арга хэмжээ авч чадвал ирээдүйд бүх хүүхдүүд гэдэс цатгалан, сургуульдаа явж, улмаар мэдлэг чадвартай боловсон хүчин бүхий нийгмийг бий болгоно.



ИНДОНЕЗИ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ
ЖОКО ВИДОДО

Дэлхийн их хүчнүүдийн хоорондох тэнцвэр алдагдаж байна. Хамтын ажиллагаа, уялдаа холбоо нуран унаж байгаа нь газрын тос, түүхий эдийн үнэд нөлөөлж, улмаар хөгжиж байгаа орнуудын валютын захыг доргиох зэрэг олон асуудлыг үүсгээд байна. Алдарт телевизийн цуврал “Хаан ширээний тоглоом” кино, зохиолд эрх мэдэл бүхий гэр бүлүүд хоорондоо тэмцэлдэж байх цаг дор, аймшигт үхэгсдийн арми хүч түрэн орж ирж байдагтай адил бид анхаарлаа буруу зүйл рүү чиглүүлж байна.

Дайн тулаанд ялсан ч бай ялагдсан ч бай, нэг л үр дүнд хүрдэг. Эвдрэл сүйрэл. Нөгөөтээгүүр живж байгаа эдийн засгийг манлайлах гэж эрмэлзэх нь өөрөө төдий л ухаалаг алхам биш юм.



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС 2018.10.24

Монголбанкнаас сар тутам зохион байгуулдаг ээлжит хэвлэлийн бага хурал энэ сарын 24-ний өдөр болж, банк санхүүгийн салбарын статистик мэдээллүүдийг хүргэж, цаг үеийн асуудлаар сэтгүүлчдийн асуултад хариулав.

БЛҮҮМБЭРГ ТВ

**ХӨГЖЛИЙН БАНКНААС ЗГ-ЫН
БАТАЛГААГҮЙГЭЭР 500 САЯ АМ.ДОЛЛАРЫН
БОНД ГАРГАСАН. ЭНЭ НЬ ТӨЛБӨРИЙН
ТЭНЦЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ВЭ?**

**МБГ-ын МБТХ-ийн захирал
Н.Ургамалсүвд:**

Хөгжлийн банкны гаргасан 500 сая ам.долларын бонд нь манай улсын төлбөрийн тэнцлийн орох урсгалын санхүүгийн дансны ашгийг нэмэгдүүлж байгаа. Тийм учраас төлбөрийн тэнцлийг сайжруулах нөлөө үзүүлнэ. Эхний найман сарын байдлаар төлбөрийн тэнцэл 400 орчим сая ам.долларын алдагдалтай гарсан. Цаашдаа ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд томоохон орох урсгалууд орж ирэхээр хүлээгдэж байгаа. Энэ урсгал нь санхүүгийн дансны ашгийг нэмэгдүүлнэ.

БЛҮҮМБЭРГ ТВ

**ТУХАЙЛБАЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ЯМАР
БАЙГУУЛЛАГААС ХЭДИЙ ХЭМЖЭЭНИЙ
САНХҮҮЖИЛТҮҮД ОРЖ ИРЭХ ВЭ?**

**МБГ-ын МБТХ-ийн захирал
Н.УРГАМАЛСҮВД:**

Он дуустал дараах томоохон урсгалууд орж ирэхээр хүлээгдэж байна. Тухайлбал, Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын хүрээнд 260 сая ам.доллар, Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд ОУВС-гаас 68.1 сая ам.доллар болон Азийн хөгжлийн банкнаас 204.5 сая ам.долларын санхүүжилт зэргийг дурдаж болно.

ИЙГЛ ТВ

**ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙГ НЭЛЭЭД
ТАНАСАН БАЙГАА. БАНКУУД ЗӨВХӨН
ӨӨРСДӨӨС НЬ ЗЭЭЛ АВСАН БАРИЛГЫН
КОМПАНИУДЫНХАА ОРОН СУУЦАНД
ЗЭЭЛ ОЛГОЖ БАЙГАА. ЭНЭ НЬ ЗОРИЛТОТ
БҮЛЭГТЭЭ ХҮРЧ ЧАДАХГҮЙ БАЙНА. ҮҮН
ДЭЭР ЦААШИД ЯМАР ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ
БОЛОМЖТОЙ ВЭ?**

**НУСЗГ-ийн СЗЗХ-ийн захирал
П.МӨНХБАЯР:**

Ипотекийн зээлийн хөтөлбөрийн тухайд санхүүжилтийг тогтмол олгож байгаа. Монголбанк 2018 он гарснаас хойш сар тутам 16 тэрбум төгрөг буюу оны эхнээс хойш нийтдээ 143.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. Энэ нь 2103 зээлдэгчид очсон статистик мэдээлэл байна. Мөн Засгийн газрын зуучлагчийн хүрээнд улсын төсөвт суулгасан 120 тэрбум төгрөгийг Монголбанк банкуудад дамжуулан олгож байна. Эхний хоёр улирлын төсвөөс нийтдээ 60 тэрбум төгрөгийн санхүүжилтийг энэ оны 4, 5 дугаар сард олгосон. Гуравдугаар улирлын 30 тэрбум төгрөгийн санхүүжилтийг энэ 10 дугаар сардаа багтаан олгоно гэдгээ банкуудад мэдэгдсэн байгаа. Дөрөвдүгээр улирлын 30 тэрбум төгрөгийг он дуустал Засгийн газраас олгоно. Мөн Монголбанк сар бүр 16 тэрбум төгрөгийг тогтмол олгох болно. Зээлдэгчдийн хувьд одоогийн мөрдөж байгаа журам, хөтөлбөрийн хүрээнд тухайн зээлдэгчид тавьж байгаа шалгуурууд бий. Энэ шаардлагыг хангасан бол хэн ч авч болохоор зохицуулалттай. Нөгөө талаас орон сууцанд тавьж байгаа шалгуурууд бий. Хөтөлбөрийн хүрээнд тавьж байгаа хамгийн гол шалтгуур нь 80 метр квадратаас ихгүй байх ёстой. Эдгээр хоёр шалгуурыг хангасан бол ямар ч зээлдэгчид олгож болно. Олон улсын байгууллагаас тавьж байгаа нэг шаардлага нь хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх ёстой. Энэ хүрээнд Засгийн газар, Монголбанк хамтраад холбогдох төлөвлөгөө, судалгааг хийж байна. Энэ хүрээнд зорилтот бүлэг дээр тодорхой өөрчлөлт орох тухай асуудал яригдаж байгаа. Гэхдээ эцэслэн шийдэгдээгүй байна.

МҮОНТ

**БАНКУУДЫН ЗЭЭЛИЙН ӨСӨЛТИЙН ТУХАЙД
АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ
БАГА ХЭМЖЭЭГЭЭР ӨССӨН. ИРГЭДИЙН
ЗЭЭЛ ИХ ХЭМЖЭЭГЭЭР ӨССӨН ДҮР ЗУРАГ**

ХАРАГДАЖ БАЙНА. ЦААШИД 2019 ОНД ӨРХИЙН ЗЭЭЛИЙН ТАЛААР ЯМАР БОДЛОГО АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ВЭ?

**МБГ-ын МБТХ-ийн захирал
Н.УРГАМАЛСУВД:**

Ирэх онд хэрэглээний зээл дээр ямар бодлого явуулах талаар бодлогын шийдвэрүүд гарсан байгаа. Өөрөөр хэлбэл, мөнгөний бодлогын хорооны 6 болон 9 дүгээр сарын хурлаар бодлогын шийдвэрүүд гарсан. 6 дугаар сард, иргэдэд олгосон хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг хамгийн ихдээ 70 хувь байхаар тогтоосон. 9 дүгээр сард иргэдэд олгосон хэрэглээний зээлийн хугацааг дээд тал нь 30 сар байхаар тогтоож өгсөн. Энэ хоёр бодлогын арга хэмжээ нь 2019 оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ. Монголбанк хэрэглээний зээлийн өсөлтийг алгуур бууруулах бодлого баримталж байна. Иргэдийн хэрэглээний зээлийг алгуур хязгаарлах замаар бизнесийн зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, ажлын байр, орлого нэмэгдүүлэх боломжийг дэмжиж байгаа юм.

ӨДРИЙН СОНИН

**"СТАНДАРТ БАНК" МОНГОЛЫН БАНКУУДЫН
ДАНСЫГ ХААСАН ГЭХ МЭДЭЭЛЭЛ БАЙНА.
ҮҮН ДЭЭР ТОДОРХОЙ МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ
БОЛОМЖ БАЙНА УУ?**

ХШГ-ын БББӨХ-ийн захирал Ё.МӨНХБАТ:

"Стандарт" банкнаас Монголын арилжааны банкуудын дансыг хаасан талаар Монголбанкинд ямар нэгэн мэдээ ирээгүй байна. Тийм учраас тодорхой хариулт хэлэх боломж алга.

Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Банкуудын макро эдийн засгийн талаарх төсөөлөл

Банкны зээлийн төлөвийн судалгаа



Олон улсын туршлагад тулгуурлан иргэд, ААН болон шинжээчдийн инфляцийн хүлээлтийг улирал бүр тооцдог.

2018 оны III улиралд явуулсан түүвэр судалгаагаар иргэд инфляцийг дунджаар 2018 оны эцэст 8.4%, ААН-үүд 4.5%, шинжээчид 8.5%-тай байхаар хүлээж байна (чанарын хариултад суурилсан тооцоо).



Судалгаанд хамрагдсан иргэдийн **86%**, бизнес эрхлэгчдийн **83%** нь 2018 оны IV улиралд инфляцийн түвшинг зорилтот түвшин болох 8%-аас бага байна гэж хүлээж байна.

Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

Банкуудын макро эдийн засгийн талаарх төсөөлөл

Банкны зээлийн төлөвийн судалгаа



Иргэдийн эдийн засгийн төлөвийн талаарх асуулгын хариултад суурилсан чиглэлийн индекс 2017 оноос тогтмол өсч байна.

- Ирэх 12 сарын хугацаанд эдийн засгийн төлөв байдал сайжирна гэсэн эерэг хүлээлттэй байгааг илэрхийлнэ.
- Ирэх 12 сарын хугацаанд өрхийн санхүүгийн байдалд нь эерэг нөлөө үзүүлнэ гэсэн хүлээлттэй байна.




Валютын ханшийн хүлээлтийн чиглэлийн индекс 2017 оны 1 дүгээр улирлаас эхлэн төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт огцом нэмэгдсэн.


2018 оны III улиралд явуулсан судалгаагаар иргэдийн дунд төгрөгийн ханш (ирэх 12 сарын хугацаанд) чангарна гэсэн хүлээлт хэвээр байв.

Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа


Банкуудын макро эдийн засгийн талаарх төсөөлөл

Банкны зээлийн төлөвийн судалгаа





Зураг 2.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц




M2 мөнгөний жилийн өсөлт 21.5%-д хүрч 17.9 их наяд ₮-т хүрэв.

Өмнөх сараас 2.7%-иар буюу 474.3 тэрбум ₮-өөр өсөв.


Үүнээс, M1 мөнгө 5.9% (190.6 тэрбум ₮), бусад хадгаламж 2.0% (283.7 тэрбум ₮) –иар өссөн байна.

- M1 → ₮-ийн харилцах 182.5 тэрбум ₮-өөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 8.2 тэрбум ₮-өөр өсөв.
- Бусад хадгаламж → \$-ийн харилцах 114.5 тэрбум ₮-өөр, ₮-ийн хадгаламж 100.1 тэрбум ₮-өөр, \$-ийн хадгаламж 69.1 тэрбум ₮-өөр нэмэгдэв.

Зураг 2.2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮





Зураг 2.3. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц



- Нийт M2 мөнгөний нийлүүлэлтийн 53.1%-ийг ₮-ийн хадгаламж бүрдүүлж байгаа бол 15.1%-ийг валютын хадгаламж, 15.4%-ийг ₮-ийн харилцах, 12.7%-ийг валютын харилцах, үлдсэн 3.6%-ийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.
- Нийт хадгаламжийн хэмжээ 12.2 их наяд ₮-т хүрснээс 83.2%-ийг иргэдийн хадгаламж, 16.8%-ийг байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.
- Иргэдийн хадгаламжийн 19.1%-ийг, байгууллагын хадгаламжийн 37.2%-ийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

Зураг 2.4. Нийт хадгаламж



Зураг 3.1. Тайлант сард олгосон ипотекийн зээл



Тайлант сард банкууд 687 зээлдэгчид 50.9 тэрбум ₮-ийн ипотекийн зээл шинээр олгосноос 28.1% нь хөтөлбөрийн, 71.9% нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.

Зураг 3.2. Тухайн сард олгосон ипотекийн зээлийн хүү



Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 12.8%-тай байна.

1966–1983

ОНЫ МӨНГӨН ТЭМДЭГТ



1960 оны 6 дугаар сарын IV хурлаар БНМАУ-ын шинэ Үндсэн хуулийг баталж, төрийн сүлдийг шинэчилсэн билээ. Иймээс шинэ мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргахаар болж, эх загварыг Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн, зураач Д.Цэрэнпил, Ц.Минжүүр нараар зуруулж, ЗХУ-ын Гознакийн үйлдвэрт хэвлүүлжээ. 1966 оны мөнгөн тэмдэгт нь 1, 3, 5, 10, 25, 50, 100-н төгрөгийн дэвсгэрттэй. 3, 5, 10, 25-н төгрөгийн дэвсгэрт бүгд адил хээ чимэглэл, бичвэртэй, 50, 100 төгрөгийн дэвсгэрт адил зураг, чимэглэл, бичвэртэй ба нэрлэсэн үнэ, өнгөөрөө ялгагдана. Серийн дугаар нь хоёр үсэг, зургаан оронтой тоотой.

1966 оны мөнгөн тэмдэгтийн эх загварын зөвхөн оныг нь өөрчлөн, 1981-1983 оны мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд дахин гаргасан байдаг. Харин 1966 оны 25-тын дэвсгэртийг хасаж, оронд нь 20 төгрөгийн дэвсгэртийг гаргажээ.



20-ТЫН ДЭВСГЭРТ

Нүүр тал: Төв хэсэгт хүрэн дотор жанжин Д.Сүхбаатарын хөргийг дүрсэлж, түүний дээд талд “БНМАУ”, “Улсын банк”, доод талд болон баруун талд суурь хээн дээр нэрлэсэн үнийг араб тоогоор тус тус бичжээ. Түүний доод талд нь “Банкны тэмдэгтүүд нь БНМАУ-ын үнэт металл, гадаадын валют бараа ба бусад активаар батлагдана.” гэсэн бичвэртэй. Зүүн талд Монгол Улсын төрийн сүлдийг дүрслэн, доод талд нь нэрлэсэн үнийг үсгээр, мөн мөнгөн тэмдэгтийн дээд хоёр буланд цэцгэн хээн дээр нэрлэсэн үнийг зурхайн тоо болон араб тоогоор, цагаан хүрэн дээр монгол бичгээр тус тус бичжээ.

Ар тал: Монгол орны бүтээн байгуулалтыг харуулсан зургийн зүүн талд суурь хээн дээр араб тоо, доод хэсэгт нэрлэсэн үнийг үсгээр бичсэн бичвэртэй. Дээд талын хүрэн дотор он, доод талд нь “Хэрэв банкны тэмдэгтүүдийг хуурамчаар үйлдвэл гэмт этгээдийг хууль ёсоор хариуцлагад татна.” гэсэн бичвэртэй. Мөнгөн тэмдэгтийн цагаан зах дээр нэрлэсэн үнийг монгол бичиг болон зурхайн тоогоор бичиж, төвд байрлах үсэг, тоогоор бичсэн нэрлэсэн үнийн дээд талд серийн дугаарыг даржээ.

1-25-ТЫН ДЭВСГЭРҮҮД

Нүүр тал: Төв хэсэгт суурь хээн дээр нэрлэсэн үнийг бичиж, дээд талд нь “БНМАУ”, “Улсын банк”, зүүн талд нь төрийн сүлдийг дүрсэлж, доод талд нь “Банкны тэмдэгтүүд нь БНМАУ-ын үнэт металл, гадаадын валют бараа ба бусад активаар батлагдана.” гэсэн бичвэртэй. Мөнгөн тэмдэгтийн дээд хоёр буланд таван дэлбээтэй цэцгэн хээг суурь болгон зурхайн тоо, араб тоогоор нэрлэсэн үнийг бичжээ.

Ар тал: Өлзий хээтэй дэвсгэр дээр зурхайн тоо болон кирилл үсгээр мөнгөн тэмдэгтийн нэрлэсэн үнийг давхардуулан бичсэн. Дээд талын хүрэн дотор оныг, доод талд “Хэрэв банкны тэмдэгтүүдийг хуурамчаар үйлдвэл гэмт этгээдийг хууль ёсоор хариуцлагад татна.” гэсэн бичвэртэй. Серийн дугаарыг улаан өнгөөр баруун доод хэсэгт дарж, дөрвөн буланд таван дэлбээтэй цэцгэн хээн дээр нэрлэсэн үнийг зурхайн тоо болон араб тоогоор, хоёр талд урт нарийн хүрэн дотор монгол бичгээр тус тус бичсэн.



50-ТЫН ДЭВСГЭРТ

Нүүр тал: Төв хэсэгт суурь хээн дээр нэрлэсэн үнийг тоогоор бичиж, түүний дээд талд “БНМАУ”, “Улсын банк”, доод талд “Банкны тэмдэгтүүд нь БНМАУ-ын үнэт металл, гадаадын валют бараа ба бусад активаар батлагдана.” гэсэн бичвэртэй. Баруун талын хүрэн дотор жанжин Д.Сүхбаатарын хөрөг, доод талд нь нэрлэсэн үнийг тоогоор, зүүн талын хүрэн дотор Монгол Улсын төрийн сүлд, доод талд нь нэрлэсэн үнийг үсгээр тус тус бичсэн. Мөнгөн тэмдэгтийн дээд хоёр буланд нэрлэсэн үнийг цэцгэн хээн дээр зурхайн тоо, араб тоогоор бичжээ.

Ар тал: БНМАУ-ын төрийн ордонг дүрслэн, доод талд нь хээн дээр зурхайн тоо болон кирилл үсгээр нэрлэсэн үнийг бичсэн бичвэртэй. Хүрэн дотор дээд талд он, доод талд “Хэрэв банкны тэмдэгтүүдийг хуурамчаар үйлдвэл гэмт этгээдийг хууль ёсоор хариуцлагад татна.” гэсэн бичвэртэй. Мөнгөн тэмдэгтийн дөрвөн буланд цэцгэн хээн дээр нэрлэсэн үнийг зурхайн тоо, араб тоогоор бичиж, доод талд бичсэн нэрлэсэн үнэ дээр “тавин төгрөг” гэж үсгээр давхар бичсэн. Мөнгөн тэмдэгтийн төв хэсэгт бичсэн нэрлэсэн үнийн дээд, доод талд серийн дугаарыг даржээ.



БАЙГАЛИЙН БАЯЛГАА ОНОВЧТОЙ БАЙДЛААР ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭНД ОРУУЛАХ, БАЯЛГИЙН ӨГӨӨЖИЙГ ХҮРТЭХ, ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТИЙН БИЙ БОЛГОХЫН ТУЛД...

Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахын тулд алсын хараатай, оновчтой бодлого чухал болохыг өнөө бидний нийгэмд үгүйлэгдэж байна. Тогтвортой өсөлтөд тогтвортой бодлого чухал болохыг “Улаанбаатарын зөвшилцөл” найман зарчимд тусгасан ба түүнийг хэрхэн тодорхойлж, хэрэгжүүлэх тухай хүргэж цувралынхаа сүүлийн хэсгийг хүргэж байна.

Бүтээмжтэй эдийн засгийг дэмжихийн тулд байгалийн баялагаа оновчтой байдлаар эдийн засгийн эргэлтэнд оруулах зарчим тулгарч байна. Энэхүү зарчмыг хангахын тулд:

Уул уурхайн салбарт түшиглэсэн томоохон төсөл, хөтөлбөрийг эдийн засгийн эргэлтэнд оруулах,

Уул уурхайн салбараас орж ирэх орлогод суурилан уул уурхайн бус, өөрийн орны онцлог давуу талд суурилсан салбарыг хөгжүүлэх замаар төрөлжилтийг бий болгох асуудал чухал байна.

Байгалийн өгөөжийг хүртэхийн тулд өмнөх 1-7 дугаар зарчим хангагдаж байвал байгалийн ерөөлд хүрэх үндэс бүрдэнэ. Манай орны хувьд эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг бий болгохын тулд эдийн засгийн төрөлжилтийг цаг алдалгүй эхлүүлэх шаардлагатай. Эдийн засгийг төрөлжүүлэх нь маш нарийн төлөвлөлт, их хэмжээний хөрөнгө оруулалтыг шаардана. Иймд манай улсын хөгжлийн стратеги нь уул уурхайн салбарт түшиглэсэн томоохон төсөл, хөтөлбөрийг эдийн засгийн эргэлтэд оруулж, түүнээс орж ирэх орлогод суурилан уул уурхайн бус, өөрийн орны онцлог давуу талд суурилсан салбарыг хөгжүүлэх замаар төрөлжилтийг бий болгож, тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгох явдал билээ.

Манай улсын хувьд сүүлийн 15 жилд, уул уурхайн томоохон /Оюу Толгой, Таван толгой/ төслүүд хэрэгжиж, Монголын эдийн засгийг дэлхийд хамгийн хурдацтай хөгжиж буй орноор, 3 сая хүн амд 1-3 их наяд америк долларын баялагтай гэж зарлагдахад нөлөөлсөн. Эдийн засгийн 90 хувийг бүрдүүлэгч, төсвийн 20 гаруй хувийг бүтээгч уул уурхайн салбараас хэт хамааралтай байдал нь түүхий эдийн үнийн мөчлөгөөс эдийн засгаа шууд хамааралтай болоход хүргээд байна.

2010 онд төсвийн тогтвортой байдлын тухай хууль баталсан ч, төсвийн зарцуулалт улс төрийн сонгуулийн мөчлөгөөс хэт хамааралтай байж бэлэн мөнгө амлах, тараах зэрэг популист бодлогууд хэрэгжсэн нь баялгийн хараалыг улам даамжруулж, цаашид өндөр инфляци үүсгэснээр томоохон хэмжээний уул уурхайн бус салбарын худалдааны тэнцлийг алдагдуулснаар илэрсэн. Төсвийн бодлогоос гадна, баялгийн хараалын шинж тэмдэг нь ашигт малтмалаас орж ирэх орлогыг хувийн хэвшилд зарцуулах /Эрдэнэс Таван Толгойн хувьцааг ард иргэдэд хуваарилах, түүнийг 2012 болон 2016 онд дахин үнэлэн худалдан авах/ шийдвэрээр илэрч байна. Байгалийн баялгийг хэрхэн ашиглаж, баялгийн хараалаас илрэх шинж тэмдгүүдээс яаж зайлсхийх нь манай орны хөгжлийн ирээдүйн зөв замыг чиглүүлнэ.

Байгалийн баялгийг ашиглан хөгжих үндсэн шат дамжлагыг дараах байдлаар тодорхойлдог. Эдгээр олон шат дамжлагыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд байгалийн баялагтай улс орнуудын Засгийн газар нь зорилтод төлөвлөгөөтэй, алсын хараатай, өндөр

чадавхтай байх шаардлагатай. Бусад орны туршлагаас харахад, дийлэнх байгалийн баялагтай эдийн засгууд нь сул засаглалтай байдаг бөгөөд энэхүү сул засаглал нь баялгийн орлогыг өөрийн эрх ашигт ашиглах гэсэн улс төрийн хүчин зүйлсээс шалтгаалж улам сулардаг. Энэхүү гинжин хэлхээг таслах нь маш том сорилт мөн.

БАЙГАЛИЙН БАЯЛАГТ ТУЛГУУРЛАН АМЖИЛТТАЙ ХӨГЖИХ ШАТ ДАМЖЛАГА НЬ ЯМАР БАЙХ ВЭ?

Байгалийн нөөцийг нээн илрүүлэх

Манай орны хувьд эхний шат дамжлагын хувьд одоогоор нээн илрүүлээд байгаа том ордуудаа эдийн засгийн эргэлтэд оруулахаас эхэлж болно. Харин цаашид байгалийн нөөцийг нээн илрүүлэхэд төр өөрийн нөөц бололцоог бүрэн дайчлах асуудал чухал хэвээр тавигдана.

Байгалийн нөөцийг ашиглах: хөрөнгө оруулалт татах

Манай орон хуримтлал багатай тул дотоод эх үүсвэрээр хөрөнгө оруулалт хийх боломж хомс юм. Иймд монголчууд өөрсдөө том ордуудыг ашиглах зорилгоор олон улсын зах зээл дээр IPO гаргаж болно.

Байгалийн нөөцийн орлогыг тогтвортой байлгах

Байгалийн нөөцийн орлогыг тогтвортой байлгах асуудал хамгийн чухал юм. Байгалийн баялгийн орлогыг хөрөнгө оруулагч, засгийн газар болон бусад оролцогчид хэрхэн хуваах тохиролцоог маш хянуур хийх ёстой. Энэ шат дамжлага нь ил тод байдал, сайн засаглал, институцитай байхыг шаарддаг буюу "байгалийн баялгийн хараал" хүрэх эсэхийг тодорхойлдог гол шат дамжлага юм. Иймд авлигаас ангижрах, сайн засаглал, институцийг бүрдүүлэх асуудал манай орны хувьд юу юунаас илүү чухал том сорилт болж байна.

Байгалийн нөөцийн орлогоор оновчтой хөрөнгө оруулалт хийх

Байгалийн баялгийн орлогыг бүрдүүлсний дараа түүнийг хэрхэн зөв зохистой зарцуулах тухай

асуудал юм. Манай орны хувьд байгалийн баялагаас орж ирсэн орлогыг нийгмийн халамж, бэлэн мөнгө тараах хэлбэрээр зарцуулсан сургамж бий. Байгалийн баялагт тулгуурлан амжилттай хөгжсөн орнуудын туршлагаас харахад, өнөөдрийн зардлыг санхүүжүүлэхээс илүүтэй ирээдүйд дараагийн орлогыг бий болгох зүйлд хөрөнгө оруулах ёстой. Манай орны хувьд төмөр зам, эрчим хүч зэрэг өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсэн, импорт болон гадаад үйлчилгээний төлбөрийг бууруулж, гадаад валютын нөөцөө нэмэгдүүлэх дэд бүтцийн төслүүдэд хөрөнгө оруулалт хийх шаардлага өндөр байна. Үүний зэрэгцээ экспортыг төрөлжүүлэх чиглэлийн төслүүдэд байгалийн баялгийн орлогоор хөрөнгө оруулалт хийх нь чухал байна.

Эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх: тогтвортой өсөлтийн суурь бүрдүүлэх

Эцсийн шат дамжлага нь бидний өмнө тулгарч эдийн засгийг, тэр дундаа экспортыг төрөлжүүлэх явдал юм. Эдгээр төрөлжилт нь манай орны хувьд тогтвортой өсөлт, хөгжлийн суурийг бүрдүүлнэ. Хүмүүн капитал, дэд бүтэц, нөөцийн салбартай уялдаатай, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай салбаруудыг дэмжих нь экспортын төрөлжилтийг бий болгож, улмаар гадаад валютын нөөц нэмэгдэх, эдийн засгийн өсөлт тогтворжиход чухал болно.

ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН: Татварын болон эрх зүйн зөв орчин бүрдүүлж, тээвэр, эрчим хүч зэргээр дэд бүтцээ сайжруулан Монгол улс эрдэс түүхий эдийнхээ баялаг нөөцийг ирэх хэдэн арван жилийн турш ашиглах баялгийн сан үүсгэх нь чухал байна. Ингэснээр салбаруудад хөрөнгө оруулалтаа шингээх нь баялгийн ерөөлд хүрэх алхмын эхлэл болох юм.

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

VIII БОГД ЖАВЗАНДАМБА ХУТАГТЫН ЭРИХ

Хосгүй үнэт

XIX зуун

Голч: 1.4 см

Эрихний бөөр чулууны голч: 1.5 см

Жин: 687 гр

Бөөрөнхий ягаан галтмар (рубелит) 108 ширхэг

Усан биндэрьяа 30 ширхэг



Уг эрихийг үнэт болон хагас үнэт чулуугаар хийсэн бөгөөд 108 эрих нь дөрвөн хэсэгт гурван том пийсүү хаалт бөөрөөр тусгаарлагдсан ба эрихний толгойд эрихийг хөдөлгөөнгүй байлгах зориулалт бүхий чулуун хүндрүүлэгч пийсүү болон номин чимэг унжлагыг тогтоосон. Тус эрих нь Манж чин гүрний үеийн хуулиар тогтоосон төрийн хувцас заслын нэгэнд тооцогдох бөгөөд хүндрүүлэгч унжлаганаас гадна тус бүр арван ширхэг эрихнээс бүрдсэн гурван унжлагатай. Тэдгээр гурван унжлаганы хоёрыг нь эрэгтэй хүн зүрхэн талдаа, эмэгтэй хүн баруун талдаа зүүдэг бөгөөд Далай ламаас бэлэглэсэн төрийн эрих, төрийн эрих зүүх журмыг анх Эээр засагч хааны (1644-1661) үед боловсруулжээ. Манж чин гүрний үед язгууртан ноёд зэрэг дэвээрээ ялгарах чулуун эрих зүүдэг байсан юм.





МОНГОЛБАНК

ТӨЛБӨР ТООЦООНЫ ГАЗАР

Төлбөрийн системийн үйл ажиллагааг зохицуулах, түүнд тавих хяналтын талаар баримтлах төв банкны бодлого, эрх зүйн зохицуулалт, дүрэм, журмыг Олон улсын төлбөр тооцооны банкнаас гаргасан зарчим, зөвлөмж болон бусад стандартад нийцүүлэн боловсруулах, шинэчлэх,

Төлбөрийн системд оролцох зөвшөөрөл авсан этгээд, түүний төлбөрийн системд хамаарах үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага, тэдгээрт холбогдох дүрэм, журам, заавар боловсруулах, шинэчлэх,

Их дүнтэй төлбөр тооцооны “БАНКСҮЛЖЭЭ” систем, олон улсын төлбөр тооцооны “СВИФТ” сүлжээний тогтвортой, тасралтгүй, найдвартай, үр ашигтай ажиллагааг ханган ажиллаж, төлбөр тооцоог үл саатуулах,

Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааны найдвартай, тасралтгүй, үр ашигтай байдлыг хангах зорилгоор хяналт тавих, газар дээрх шалгалт хийх, хяналт шалгалтын тайлан бэлтгэх, холбогдох арга хэмжээ авах, зөвлөмж, дүгнэлт гаргах,

Төлбөрийн системийн үйл ажиллагаатай холбоотой тайлан, судалгааг хийх, төлбөрийн системийн хяналт, шалгалтын тайланг жил бүр гаргах, олон нийтэд ил тод болгох,

Банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцооны систем, картын нэгдсэн сүлжээний тогтвортой, тасралтгүй, найдвартай, үр ашигтай ажиллагааг ханган ажиллах,

Банк хоорондын бага дүнтэй болон картын нэгдсэн сүлжээний гүйлгээг боловсруулах, төлбөр тооцооны үр дүнг тооцоолох, төрийн байгууллагын төлбөр тооцоог гүйцэтгэх.





А.БАТСАЙХАН: ЦАХИМ МӨНГӨНИЙ ХЭРЭГЛЭГЧ БОЛСНООР ЦАГ ХУГАЦАА, ЗАРДЛАА ХЭМНЭХ БОЛОМЖТОЙ

Цахим мөнгө болон төлбөр тооцооны системд нэвтрүүлж буй шинэ үйлчилгээний талаар Монголбанкны Төлбөр тооцооны газрын ахлах мэргэжилтэн А.Батсайхантай ярилцлаа.

Зарим байгууллага цахим төлбөрийн шинэ хэлбэрийг нэвтрүүлж байна. Тухайлбал, "Candy" цахим мөнгө албан ёсоор хэрэглээнд нэвтэрч эхэллээ. Давуу тал, ач холбогдлын тухайд ямар байх бол?

"Мобифинанс" банк бус санхүүгийн байгууллагаас гаргаж буй "Candy" цахим мөнгөнд албан ёсны зөвшөөрөл олгосон. Энэ нь Монгол Улсад цахим мөнгө гаргахаар олгож буй анхны зөвшөөрөл гэдгээрээ онцлогтой. Энэхүү цахим мөнгийг хэрэглэгч талаас харвал төгрөгтэй яг адилхан төлбөр тооцоонд ашиглана. Цахим мөнгийг ашиглаж алсын зайнаас шилжүүлэг хийдэг, гэж үрэгдүүлэх эрсдэл бага гэх мэт бэлэн мөнгөнөөс олон давуу талтай. Цахим мөнгөний

хэрэглэгч болоход маш хялбар. Гар утаснаасаа мессеж бичээд л ашиглах боломжтой болно. Биеэр очиж бүртгүүлэх, гэрээ байгуулж гарын үсэг зурах зэрэг чирэгдэлтэй үйлдэл байхгүй. Нөгөө талаас үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд цахим мөнгө гаргаж буй газартай нэг удаа гэрээ байгуулснаар төлбөр тооцоондоо ашиглах боломжтой юм. Ингэхэд шинээр төхөөрөмж худалдан авах, бүртгэлийн хураамж гэх мэт нэмэлт зардал шаардахгүй. Мөн бэлэн мөнгө хүлээн авч хадгалах, тээвэрлэх эсвэл банкинд тушаах гэх мэт үйл ажиллагаанд зарцуулдаг цаг хугацаа, зардлаа хэмнэх бүрэн боломжтой бөгөөд зөвхөн цахим мөнгөний гүйлгээ тутамд бага хэмжээний шимтгэл төлнө.

Нэг "Candy" нэг төгрөгтэй

тэнцэнэ гэж байгаа. Тэгэхээр хэрэглэгч яаж "Candy"-тэй болох вэ?

"Candy" үйлчилгээний хувьд хэрэглэгч "Мобифинанс" банк бус санхүүгийн байгууллагад төгрөгөө өгөх ёстой. Ингэхдээ банкаар дамжуулах эсвэл бэлнээр өгөх эсэх нь тухайн хэрэглэгчийн шийдэл. "Мобифинанс"-аас тухайн төгрөгийг өөрийнхөө дансанд байршуулж, оронд нь хэрэглэгчид "Candy" өгнө. Түүгээр тухайн хэрэглэгч худалдан авалт хийх боломж бүрдэх юм.

Үйлчилгээний байгууллагууд цахим мөнгөөр гүйлгээ хийх талд хэр зэрэг бэлтгэлтэй байна?

Дэлгүүр, цайны газар зэрэг зарим байгууллага аль хэдийнэ гүйлгээ хийж эхэлсэн байгаа.

Цахим мөнгөөр гүйлгээ хийж буй хэрэглэгчийг хохироохгүйн тулд аюулгүй байдалд нь Монголбанк ямар байдлаар хяналт тавих вэ?

Холбогдох хууль журмын хүрээнд цахим мөнгөний үйл ажиллагааг Монголбанк хянаж, цахим мөнгө гаргах гэж буй бүх этгээдэд мөн зөвшөөрөл олгоно. Цахим мөнгөний эрх зүйн зохицуулалтын хувьд шинээр оруулж ирсэн нэг зүйл нь баталгааны данс юм. Цахим мөнгийг хэдий хэмжээгээр гаргах гэж байна, түүнтэй тэнцүү хэмжээний мөнгөн хөрөнгийг банкны дансанд баталгаа болгож байршуулах ёстой. Баталгааны дансан дахь мөнгөн хөрөнгийг өөр ямар нэгэн зориулалтаар ашиглаж болохгүй, зөвхөн хэрэглэгчийн цахим мөнгийг төгрөгт хөрвүүлэхэд л ашиглана. Ийм баталгаа гаргаснаар эцсийн хэрэглэгчийг цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч дампуурах эрсдэлээс баталгаатай хамгаалах маш хүчтэй зохицуулалт болсон.

Монгол Улсад гадаад, дотоод төлбөрийн шилжүүлгийг ямар хяналт дор явуулдаг вэ. Хүмүүс Монголбанк хянадаг гэж ойлгодог?

Монгол Улсын нутаг дэвсгэрт хийж буй гүйлгээг хуулийнхаа хүрээнд Монголбанк зохицуулдаг. Харин Монгол Улсаас гадагшаа гарах, дотогш орох олон улсын гүйлгээнд манай улсын төлбөрийн системийн хууль дүрэм үйлчилдэггүй. Банкууд тус тусдаа олон улсын сүлжээний гарцтай байдаг. Тэд үүнийгээ ашиглаж олон

улсын гүйлгээ хийдэг. Тиймээс Монголбанкнаас олон улсын гүйлгээнд ямар нэгэн зохицуулалт хийдэггүй.

Тэгэхээр зарим банкны гадаад гүйлгээний данс хаагдсан тохиолдолд, мөн гаднаас оруулж ирж буй мөнгө угаах гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй сэжигтэй, ихээхэн хэмжээний мөнгөний гүйлгээ зэргийг Монголбанк зохицуулж, хянах боломжтой юу?

Аль нэгэн банкны гадаад гүйлгээний тухайн дансыг олон улсын хууль дүрмээр зохицуулж байгаа учраас Монголбанк үүнд нөлөөлөх ямар нэгэн боломжгүй. Харин гаднаас оруулж ирж буй мөнгө угаах гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй сэжигтэй, ихээхэн хэмжээний мөнгөний гүйлгээг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд зохицуулсан байдаг. Тухайлбал, 20 сая төгрөгөөс дээш гүйлгээ хийсэн тохиолдолд холбогдох газарт нь бүртгүүлэх ёстой гэсэн заалт бий.

Сүүлийн үед олон улсад мөнгөн гуйвуулгыг хэд хэдэн төрлийн цахим хэлбэрээр хийдэг боллоо. Энэ мэтээр санхүүгийн салбар эрчимтэй технологжиж байгаа ийм үед Монголбанк бодлогын төвшинд хэр бэлэн байна вэ?

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг энэ жил мөрдөж эхэлсэн. Энэ хуулийг хэрэгжүүлснээр төлбөрийн системд банкнаас бусад байгууллагыг оролцуулах хууль эрх зүйн боломж нээгдэж байгаа. Энэ хүрээнд эхний

ээлжинд Монголбанкнаас цахим мөнгөний журмыг боловсруулж батлуулсан бөгөөд цахим мөнгө гаргах санхүүгийн үйлчилгээг банкнаас бусад ХХК үзүүлэх боломжтой болсон. Цаашид төлбөрийн картын болон бага дүнтэй төлбөрийн системд банкнаас бусад байгууллагыг хэрхэн оролцуулах боломжтой талаар судалж, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлж, оролцох боломжийг нь нээхээр ажиллаж байна.

Олон улсын санхүүгийн салбарын чиг хандлагын талаар сүүлийн үеийн ямар мэдээлэл байна вэ?

-Олон улсын санхүүгийн зохицуулах байгууллагуудын ахаарлыг татаж буй нэг сэдэв бол яалт ч үгүй криптовалют, үүний ард ашиглаж буй блокчэйн технологи юм. Энэ технологийг төлбөрийн системд тодорхой хэмжээнд ашиглах боломж бий. Тиймээс зарим улсын төв банк үүнийг төлбөрийн системд яаж ашиглах талаар судалгаа явуулж, туршилт хийж байна. Жишээлбэл, Сингапур улсын Мөнгөний бодлого хэрэгжүүлэгчээс блокчэйн технологийг их дүнтэй төлбөрийн системд ашиглах талаар урт хугацааны туршилт хийж, энэ талаарх тайлангаа олон нийтэд мэдээлсэн. Үүнд "Блокчэйн технологи одоохондоо арай шинэ, үүнийг ашигласнаас гарах үр өгөөж нь хангалттай хэмжээнд хүрээгүй байна. Харин нэмэлт зардал нь өндөр байгаа учраас одоохондоо их дүнтэй төлбөрийн системд ашиглахгүй. Гэхдээ энэ технологи маш хурдацтай хөгжин шинэчлэгдэж

байгаа учраас туршилтаа цааш нь үргэлжлүүлнэ. Хэзээ нэгэн цагт ашиглах боломж бүрдэж магадгүй” гэсэн дүгнэлт гаргасан.

**Манай улсын хувьд
криптовалютын талаар ямар
бодлого барьж ажиллаж байна вэ?**

Криптовалютын тухайд Монголбанкнаас хоёр, Санхүүгийн зохицуулах хорооноос нэг удаа мэдэгдэл гаргасан. Тодруулбал, криптовалюта нь өндөр эрсдэлтэй, үүнийг хянах зохицуулах байгууллага байдаггүй болохоор үүнд хөрөнгө оруулж, ашиглаж байгаад хохирсон тохиолдолд буцаан олох ямар ч боломжгүй байдаг тул болгоомжтой хандахыг анхааруулсан. Нөгөө талаас Монгол Улсын нутаг дэвсгэрт төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд бараа ажил үйлчилгээний төлбөрийг зөвхөн төгрөгөөр гүйцэтгэнэ гэж заасан. Тиймээс биткойныг төлбөрт ашиглаж болохгүй, ашигласан тохиолдолд хууль бус үйлдэл болно. Одоогийн байдлаар ийм зохицуулалттай байна.

**Дэлхий нийтэд энэ технологийг
ажиглаж байна гэсэн дүгнэлтэд
хүрээд байгаа энэ үед манай улс
цаашид ямар шийдэлд хүрэх
ёстой вэ?**

Дэлхий нийтийн хувьд криптовалюта болон блокчэйн технологийн хөгжлийг ажиглаж

байгаа учраас Монголбанкны зүгээс мөн адил тодорхой хэмжээнд харзсан байдалтай байна. Гэхдээ харж байна гээд нь гар хумхиж зүгээр суугаагүй, блокчэйн технологи түүний хэрэглээг судалах ажлын хэсэг байгуулсан, ажлын хэсэг нь эхний тайлангаа Монголбанкны удирдлагуудад танилцуулсан. Холбогдох хуульд криптовалютыг төлбөрийн хэрэгсэл болгон ашиглаж болохгүй гэж заасан нь ойлгомжтой, харин хөрөнгө оруулалт маягаар ашиглах шинж чанар байна. Энэ нь төлбөрийн системийн зохицуулах асуудал биш учраас үүнийг Монголбанк дангаараа зохицуулах боломжгүй.

**Монголбанк орчин үеийн
чиг хандлагатай уялдуулан
ямар бодлого, чиг хандлага
баримталж байна?**

Бид бэлэн мөнгөний хэрэглээг багасгах, цахим төлбөр тооцоог дэмжих, төлбөрийн шинэлэг хэрэгсэл, санхүүгийн үйлчилгээг бий болгох боломжийг бүрдүүлэх бодлого, чиг хандлага баримталж байна. Энэ хүрээнд цахим төлбөр тооцоог дэмжих зорилготой хоёр сарын аянг Монголбанкнаас зарласан. Аяны зорилго бол цахим төлбөр тооцоог сурталчлах, иргэн бүрт таниулах явдал юм.

**Санхүүгийн салбарын
технологийн хөгжил дэвшлийг
цаг алдалгүй Монголд**

нэвтрүүлж чадаж байна уу?

Санхүүгийн тэр дундаа төлбөрийн системийн хөгжил дэвшил дэлхийн хөгжилтэй нэлээд ойрхон явж байна. Жишээлбэл, Монгол Улсад бага буюу нэг сая төгрөгөөс ба түүнээс доош дүнтэй банк хоорондын төлбөр тооцоог бодит цагийн горимд явуулдаг болсон. Тодруулбал, нэг хэрэглэгч гүйлгээ хийсэн тэр даруйд хүлээн авагчийн дансанд орж байна. Энэ тогтолцоог дэлхий нийтэд цөөхөн улс орон нэвтрүүлсэн байдаг. Түүний нэг нь манай улс.

**Төлбөрийн картын тухайд олон
улсад нэвтрүүлсэн үйлчилгээг
нэвтрүүлж чадаж байна уу?**

Монгол Улсад бүх төрлийн төлбөрийн карт гарч байна. Олон улсын схемээс гаргадаг картын хувьд ашиглахад харьцангуй нээлттэй байдаг, дотоодын ₮ буюу үндэсний төлбөрийн картын тухайд Монголбанкнаас зөвшөөрөл олгодог. Ирэх онд ₮ картыг олон улсын стандарт хангасан чиптэй болгохоор ажиллаж байна. Ингэснээр хулгай залилангийн гүйлгээ гарахгүй, мөн төлбөрийн шинэ үйлчилгээ нэвтрүүлэх боломжтой болно. Жишээлбэл, иргэн ₮ картаа ашиглан автобусны төлбөрөө төлөх эсвэл дэлгүүрээс худалдан авалт хийхдээ зайнаас уншуулах гэх мэт шинэлэг үйлчилгээ ашиглах боломжтой болно.



ЭХ ОРНЫХОО АЛТЫГ ЭРДЭНЭСИЙН САНДАА

Саяхныг хүртэл алт олборлогчид олборлосон алтаа тушаах гэж алс замыг туулж Улаанбаатарт ирж байв. Ирээд сорьц тогтоолгох гэж өчнөөн шат дамжлага, урт дараалалд цагийг бардаг байж. Магадгүй энэ төвөгтэй байдал нь албан бус алт худалдан авалтыг өөгшүүлэх нэгэн шалтгаан болж байв. Сүүлийн хоёр жилд монголоос олборлосон алт хууль бусаар хилийн чандад гарахгүй болсныг гэрчлэх тоо бол өнгөрсөн жил 20 тн алт Монголбанкинд тушаагдсан явдал юм. Ингэж түүхэндээ өндөр үзүүлэлтийг үзүүлсэн өсөлт анх удаа тохиосон нь бодлогын арга хэмжээний үр дүн юм. Эхний алхам нь үнийн бодлого шинэчлэгдэж, Лондонгийн үнэт металлын биржийн үнийг баримталсан нь алт борлуулагчдад нээлттэй зах зээлийг бий болгосон явдал байв. Дагаад мэдээллийн хязгаарлагдмал байдлыг бууруулж, албан худалдан авалтын ач холбогдлыг сурталчилсны үр дүн энэ байв.

Хоёр дахь алхам бол алт сорьцлолт, албан ёсны алт худалдан авалтыг алтны уурхай бүхий бүсүүдэд ойртуулсан нь бүр ч илүү боломжийг олгоод зогсохгүй алтны худалдааны албан бус сүлжээг бууруулах нөхцөлийг бүрдүүлж байна.

АРАВДУГААР САР, ДОТООДЫН АЛТНЫ АРИЛЖААНД ТҮҮХЭНД ТЭМДЭГЛЭГДЭХ ҮЙЛ ЯВДЛЫГ ҮЛДЭЭЛЭЭ

Монголбанк, Стандарт хэмжил зүйн газрын харьяа Үнэт металлын сорьцын хяналтын газар болон Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төсөл хамтран алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулах, ил тод болгох, алтны худалдааны төвлөрлийг сааруулах зорилгоор Дархан-Уул болон Баянхонгор аймагт алтны сорьц тогтоох, худалдан авах нэг цэгийн үйлчилгээний төвийг байгууллаа. Энэ хүрээнд Монголбанк болон Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой



бичил уурхай” төслөөс хамтран нийт 790 орчим сая төгрөгийн санхүүжилтийг шийдсэнээр орон нутагт алт, үнэт металлын сорьц тогтоох сүүлийн үеийн тоног төхөөрөмжүүдийг хүлээлгэн өгөв.

Монгол Улсын Засгийн газраас зарласан “Алт-2” үндэсний хөтөлбөр, Монголбанкнаас хэрэгжүүлж буй “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяны хүрээнд алтны салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулах, олборлосон алтыг зөвхөн Монголбанкинд тушаадаг байх таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар улс орны гадаад валютын нөөцийг бүрдүүлэхэд томоохон дэмжлэг үзүүлэхийг зорьж буй.

АЛТЫГ ОРОН НУТАГТ СОРЬЦОЛДОГ БОЛНО ЧИНЭЭ САНАЖ БАЙСАНГҮЙ

Орон нутагт нээх эхний лабораторийг төвийн бүсийг хамруулахаар Дархан-Уул аймагт 9 дүгээр сарын 16-нд нээлээ. Хуучнаар улсын хоёр дахь нийслэл Найрамдлын Дархан хот байгуулагдсан өдөр ойрхон тохиосон нь алтны салбарт бүтээж буй нэгэн шинэ түүх хот байгуулагдсан түүхтэй давхцаж





байгаад хотын иргэд талархан билэгшээлээ.

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан өөрийн биеэр хүрэлцэн очиж, Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэхэд онцгой хувь нэмэр оруулах энэхүү лабораторын үйл ажиллагааг нээхдээ Монгол эх орны хөрсөн дэх алтны үнэ цэнэ эх нутагтаа үлдэхийн ач холбогдлыг хэлж, үеийн үед мөнхөд орших тусгаар тогтнолын бат илэрхийлэл болсон үндэсний мөнгөн тэмдэгтэд алт нь суурь баталгаа болохын хувьд “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” тушааж, албан бус сүлжээгээр харьд зөөх биш албан худалдан авалтыг төлөвшүүлэхэд энэхүү үйл ажиллагаа өндөр ач холбогдолтой гэж байв.

Энэ үеэр Дархан-Уул аймгийн унаган иргэн Т.Тунгалаг алтны сорьц тогтоох төвийн анхны үйлчлүүлэгч болж, 238.8 грамм алтыг сорьцуулж, Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэст тушаалаа. Тэрбээр Монголбанкинд өөрийн биеэр ирж, жилд дунджаар 400 кг алт тушаадаг байжээ. Харин одоо их баяртай байгаагаа илэрхийллээ. Учир нь түүний хувьд амаргүй үеүүд ард хоцорлоо гэж үзэж байв. Түүнтэй ярилцахад, алт тушаах нь багаггүй эрсдэлтэй аж. Замаасаа алдана, сорьцуулах гэж урт дараалалд өнжинө, мэдээж энэ бүхнийг дагаад зардалтай гэхчлэнгээр бэрхшээл цөөнгүй. Гэтэл энэ мэт шат дамжлагыг тээршаах хүмүүс албан бус сүлжээгээр алтаа борлуулах нь цөөнгүй аж.

Ийнхүү орон нутаг дахь үнэт металлын сорьц тогтоох лаборатори бүхий алт худалдан авах нэг цэгийн үйлчилгээний төвийн анхны шанг татсанаас долоо хоногийн дараа баруун бүсэд Баянхонгор аймагт удаах үйл ажиллагаагаа нээв. Анхны өдөр иргэн Н.Өлзийбаатар 1.7 кг алт тушаалаа. Ингэж эдгээр иргэд орон нутаг дахь алтны сан хөмрөгийг нээснээс хойш арваад хоногийн дотор буюу аравдугаар сарын 31- ний өдрийн байдлаар тус аймгууд нийт 50.1 кг алтыг худалдан аваад байна. Энэ онд Монголбанк алт худалдан авалтаа 22 тоннд хүргэх зорилт дэвшүүлсэн. Тэгвэл, аравдугаар сарын эцсийн байдлаар иргэд, аж ахуйн нэгжүүдээс 17.2 тонн алт худалдан авч зорилтоо хангахад ойртоод байна.

**ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ.ДОЛЛАРААР, 26/Х ӨДРИЙН БАЙДЛААР)**



ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖИЛ, САНХҮҮЖИЛТИЙН БАЙДАЛ

Судлаач С.Билгүүн, О.Цолмон, Б.Хүслэн, С.Билгүүнзул, Г.Мөнхбаяр, Э.Элбэгжаргал (Монголбанк, Судалгаа статистикийн газар)

Энэхүү түүвэр судалгаагаар жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилт, тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлохыг зорьсон бөгөөд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд түлхүү чиглэв.

1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

1.1. Удиртгал

Жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ) нь улс орнуудын эдийн засагт тэр дундаа хөгжиж буй орнуудын хөгжилд онцгой үүргийг гүйцэтгэдэг. Дэлхийн банкны судалгааны үр дүнд ЖДҮ нь хөгжиж буй улсуудын ажил эрхлэлтийн 40%, дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ний 60 хүртэлх хувийг дангаар бүрдүүлдэг байна. Иймд ЖДҮ-ийн салбарыг эрчимтэй дэмжиж, бодлогоор хөгжсүүлэх нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахын зэрэгцээ хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бүрдүүлэх гол тулгуур нь болж өгнө.

2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ, ДЭМЖЛЭГ


2.1. Ерөнхий мэдээлэл

Энэхүү бүлгээр судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгч ААН-үүд болон иргэдийн ерөнхий мэдээллийг танилцуулж байна.

БИЗНЕСИЙН ТОО

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 75% нь зөвхөн нэг чиглэлээр бизнес эрхэлдэг бол үлдсэн хувь нь олон төрлийн салбарт бизнесийн үйл ажиллагаа явуулдаг байна /Зураг 2.1/.

Зураг 2.1 | Бизнесийн тоо




Эх сурвалж: ЖДҮ-ийн түүвэр судалгаа -2018

ЖДҮ эрхлэгчдээс санал асуулгыг цаашид зөвхөн үндсэн бизнесийн хувьд асуулаа.

АЖИЛЛАГСДЫН ТОО

Зураг 2.2 | Ажиллагсдын тоо



Эх сурвалж: ЖДҮ-ийн түүвэр судалгаа -2018


Зураг 2.2-т судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн үндсэн бизнес дэх ажиллагсдын тоог бүлэг болгон харуулж байна /Зураг 2.2/.

Зургаас харахад ЖДҮ эрхлэгчдийн 86% нь 1-10 хүртэлх тооны ажиллагсадтай, 10% нь 11-30 хүртэлх тооны ажиллагсадтай, үлдсэн хэсэг нь 31 болон түүнээс олон тооны ажиллагсадтай байна. Өөрөөр хэлбэл, судалгаанд бичил бизнес эрхлэгчид түлхүү хамрагдлаа.

ЖИЛИЙН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

Санал асуулгад оролцсон ЖДҮ эрхлэгчдийн жилийн борлуулалтын орлогын мэдээллийг Зураг 2.3-т харуулж байна.

Зураг 2.3 | Борлуулалтын орлого




Эх сурвалж: ЖДҮ-ийн түүвэр судалгаа -2018

Судалгаанд оролцогчдын тэн хагас нь буюу 46% нь 50-499 сая төгрөгийн жилийн борлуулалтын орлоготой байна. Харин 36% нь 10-49 сая төгрөгийн, 12% нь 9.9 сая төгрөгөөс бага борлуулалтын орлоготой буюу бичил бизнес эрхэлдэг байна. Жилийн борлуулалтын орлого хамгийн өндөр (500 саяас 1 тэрбум төгрөгийн орлоготой) ЖДҮ эрхлэгчид нийт түүврийн 6%-ийг эзэлж байна.

АЖ АХУЙ НЭГЖИЙН ХЭЛБЭР

Зураг 2.4-т судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийг аж ахуй нэгжийн хэлбэрээр нь 6 бүлэгт ангилан харуулж байна.

Зураг 2.4 / ААН-ийн хэлбэр




Эх сурвалж: ЖДҮ-ийн түүвэр судалгаа -2018

Зургаас харахад судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 49% нь хувиараа, 42% нь хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр бизнес эрхэлдэг байна. Харин нөхөрлөл, хувьцаат компани, хоршоо хэлбэрээр бизнес эрхлэгчдийн тоо судалгааны нийт түүвэрт тус бүр 2%-ийг эзэлж байна.

АЖ АХУЙ НЭГЖИЙН ӨМЧЛӨЛИЙН ХЭЛБЭР

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийг өмчлөлийн хэлбэрээр нь авч үзвэл дийлэнх хэсэг нь буюу 98% нь дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүд байна. Харин нийт түүврийн 1%-ийг гадаадын хөрөнгө оруулалттай, мөн 1%-ийг холимог өмчлөлтэй ЖДҮ эрхлэгчид эзэлж байна /Зураг 2.5/.

Зураг 2.5 / Өмчийн хэлбэр



Эх сурвалж: ЖДҮ-ийн түүвэр судалгаа -2018

2.2. Дэмжлэг

Энэхүү бүлэгт ЖДҮ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлдэг байгууллагууд болон үзүүлж буй дэмжлэгүүд, цаашид авах арга хэмжээнүүдийн талаар танилцуулж байна.

Одоогийн нөхцөл байдал


Зураг 2.11-т ЖДҮ эрхлэгчдийг үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлдэг байгууллагуудыг харуулж байна. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх (29%) нь арилжааны банкууд ЖДҮ эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг гэж хариуллаа. Энэ нь өмнөх жилийн судалгаануудад мөн ажиглагдсан. Түүний дараагаар орон нутгийн засаг захиргаа, бусад санхүүгийн байгууллагууд, худалдаа, аж үйлдвэрийн танхим, засгийн газар зэрэг бусад байгууллагууд орлоо. Харин зөвлөгөө өгөх байгууллага, төвүүд болон олон улсын байгууллагуудын ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэг хамгийн бага гэсэн үр дүнтэй гарлаа /Зураг 2.11/.

Зураг 2.11 | ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж буй байгууллагууд

Эх сурвалж: ЖДҮ-ийн түүвэр судалгаа -2018

Зураг 2.11-т ЖДҮ эрхлэгчдэд хамгийн ихээр ирдэг дэмжлэгүүдийг харуулж байна. Судалгааны дүнгээр манай улсад ЖДҮ эрхлэгчдэд голчлон санхүүжилт олгох, сургалт, зөвлөгөө явуулах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, дэд бүтцийг сайжруулах замаар дэмжлэг үзүүлдэг байна.

3. БИЗНЕСИЙН ОРЧИН

Зураг 3.1 | ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин /-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/

Эх сурвалж: ЖДҮ-ийн түүвэр судалгаа -2018

Санал асуулгын дүнг нэгтгэж, бизнесийн орчны ерөнхий индексийг тооцоход нийгэм улс төрийн

орчин (-0.59), макро эдийн засгийн орчин (-0.40), санхүүжилтийн орчин (-0.52), хууль эрх зүй, төрийн зохицуулалтын орчин (-0.35), зах зээлийн орчин (-0.13), дэд бүтцийн орчин (0.00) гэсэн үнэлгээтэй гарлаа /Зураг 3.1/. Үнэлгээнээс харахад манай улсын ЖДҮ эрхлэгчдэд нийгэм улс төрийн байдал, макро эдийн засгийн нөлөө, санхүүжилтийн орчин болон хууль, эрх зүйн зохицуулалт гол хүндрэл учруулж байна.

Зураг 3.2 | ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин / үзүүлэлтээр/ /-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/

Эх сурвалж: ЖДҮ-ийн түүвэр судалгаа -2018

Харин дэд бүтцийн хөгжил, зах зээлийн орчин боломжийн буюу бусад орчны индекс тэй харьцуулахад бага хүндрэл учруулж байна.

Бизнесийн орчинд нөлөөлөх хүчин зүйлсийг үзүүлэлт тус бүрээр нь үнэлж жагсаахад ЖДҮ эрхлэгчид зээлийн нөхцөл (хүү, хугацаа, шимтгэл), ажилгүйдэл, улс төрийн байдал, хээл хахууль, валютын ханш болон инфляци бусад үзүүлэлттэй харьцуулахад хамгийн их хүндрэлтэй байна гэж үзжээ. Харин технологийн дэвшил болон дэд бүтцийн асуудлууд хүндрэл багатай гэж хариулсан байна /Зураг 3.2/.


4. САНХҮҮЖИЛТИЙН БАЙДАЛ

4.1. Өнгөрсөн хугацаанд санхүүжилтэнд хамрагдсан байдал

Санхүүжилт авсан байдал, нэгдсэн дүн

Энэхүү хэсэгт хариулсан нийт 1,864 ЖДҮ эрхлэгчдийн 760 нь буюу 41% нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэх болон бизнесээ өргөтгөх зорилгоор тодорхой хэмжээний гадаад санхүүжилт авсан бол 54% нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд санхүүжилт аваагүй байна. Харин үлдсэн 5% нь мэдэхгүй гэж хариулжээ /Зураг 4.1/.

Зураг 4.1 | ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилт авсан байдал (ЖДҮ-ийн хариулсан хувиар)




Эх сурвалж: ЖДҮ-ийн түүвэр судалгаа -2018

Санхүүжилт авсан байдал, салбараар

Салбарын ангиллаар авч үзвэл өнгөрсөн нэг жилийн хугацаанд үйлдвэрлэл эрхлэгчдийн 48% нь, ХАА-н салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн 45% нь санхүүжилт авч байсан дүн гарсан нь худалдаа болон үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийн санхүүжилтэд хамрагдсан хувиас 8-9 нэгж хувиар өндөр байна /Зураг 4.2/.

Зураг 4.2 | Санхүүжилт авсан байдал /салбараар/ (ЖДҮ-ийн хариулсан хувиар)



Эх сурвалж: ЖДҮ-ийн түүвэр судалгаа -2018

Эндээс харахад ХАА болон үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд санхүүжилтийн хэрэгцээ худалдаа, үйлчилгээний салбарын ЖДҮ эрхлэгчтэй харьцуулахад өндөр байдаг байна.

Санхүүжилтийн эх үүсвэр

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд санхүүжилтэд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь буюу 76% нь банкны зээл болон 12% нь хөнгөлөлттэй зээл авч санхүүжилтийн эх үүсвэрээ бүрдүүлжээ /Зураг 4.3/.

Зураг 4.3 | Санхүүжилтийн эх үүсвэр (ЖДҮ-ийн хариулсан хувиар)



Эх сурвалж: ЖДҮ-ийн түүвэр судалгаа -2018

5. Бизнесийн дотоод үйл ажиллагаа

5.1. Дотоод үйл ажиллагаанд нөлөөлж буй хүчин зүйлс

Нэгдсэн дүн

ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулахад дотоод орчны хувьд нөлөөлөх хүчин зүйлсийг ажиллах хүчний ур чадвар, ажиллах хүчний нийлүүлэлт, байгууллагын өрсөлдөх чадвар, бүтээгдэхүүний борлуулалт, барилгын хүрэлцээ, тоног төхөөрөмжийн чанар, түүхий эдийн олдоц, хүний нөөцийн бодлого болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж зэрэг үзүүлэлтүүдээр төлөөлүүлэн авч судаллаа

Судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчид дотоод үйл ажиллагааны нөхцөлийг боломжийн (0.26) гэсэн үнэлгээг өглөө. ЖДҮ эрхлэгчдэд дотоод хүчин зүйлсээс ажиллах хүчний нийлүүлэлт бага зэрэг хүндрэл учруулдаг гэж үзэж байна. Харин байгууллагын өрсөлдөх чадвар, тоног төхөөрөмжийн чанар болон ажиллах хүчний ур чадварыг илүү сайнаар нөлөөлдөг гэсэн үнэлгээг өгсөн байна.

Ш.АЛТАНЦЭЦЭГ: ХАНШ СУЛАРЛАА, ХАНШАА АЛДЛАА ГЭЖ ЗАРИМ НЬ ШҮҮМЖИЛЖ БАЙГАА Ч ТИЙМ БИШ

Дэлхийн банкны Монгол Улсыг хариуцсан эдийн засагч Ш.Алтанцэцэгтэй Монгол Улсын болоод бүс нутгийн эдийн засгийн ойрын ирээдүйн төлвийг ярилцлаа.



Монгол Улсын эдийн засаг сэргэж эхэлснийг хаана хаанаа хүлээн зөвшөөрч буй. Гэхдээ түүний үр нөлөө энгийн иргэдэд төдийлөн мэдрэгдэхгүй байна гэсэн шүүмжлэл ч байна. Үүнд ямар тайлбар хэлэх вэ?

-Дэлхийн банк Монгол Улсын эдийн засаг энэ онд 5.9, ирэх 2019 онд 6.6 хувийн өсөлт үзүүлэх болов уу гэсэн таамаг дэвшүүлж байна. Энэ оны эхний хагас жилд 6.3 хувиар өслөө. Харин сүүлийн хагас жилд ингэж өндөр өсөхгүй байх гэж таамагласан. Монгол Улсын уул уурхайн экспортын орлого ихээр нэмэгдсэн. Түүнээс үүдээд үйлчилгээний олон салбарт нааштай үзүүлэлт ажиглагдаж байна. Эдийн засгийн өсөлт жигдэрч, хүрээгээ тэлснээр иргэдийн амьжиргаанд тодорхой нөлөө үзүүлнэ гэсэн үг. Өрхийн бизнес идэвхжиж байгааг дагаад өрхийн зээл нэмэгдэж, бодит орлого өссөн харагдаж байна.

Валютын ханшийн өсөлтөд хэрэглэгчид санаа зовниж байна. Төгрөгийн ханшийг барих талаар Монголбанкийг тодорхой арга хэмжээ авахгүй байна гэсэн шүүмжлэл ч гарч байна?

-Төгрөгийн доллартай харьцах ханшийг харж ханш суларлаа, ханшаа алдлаа гэж зарим нь шүүмжилж байна. Тийм биш гэж хэлье. Энэ оны эхнээс ОУ-ын зах зээлийн нөхцөл байдлаас ам долларын ханш олон мөнгөн тэмдэгтийн эсрэг чангарч эхэлсэн. Тухайлбал МУ-тай төстэй уул уурхайн бүтээгдэхүүнээс орлогоо бүрдүүлдэг улсуудын, тухайлбал Чили, Орос, Аргентин улсын мөнгөн тэмдэгтүүд үргэлжлэн суларсаар байна. Аргентин улсын мөнгөн тэмдэгт 100 гаруй хувь, Орост рубль 15 хувиар, Хятадад юань мөн долларын эсрэг 6 хувиар тус тус сулраад байна. Тэдэнтэй харьцуулахад төгрөгийн 09 сарын 17-ны 2,500 төгрөг хүрсэн ханшийг энэ оны эхэнтэй харьцуулахад 3.5

хувь, харин өнгөрсөн 6 сарын эцэстэй харьцуулахад 1.9 хувиар суларсан байна. Бидэнд долларын ханш хурдтай чангараад байгаа юм шиг санагдавч ч дэлхийн бусад улсуудтай харьцуулахад дотооддоо удирдаж, хяналтдаа авч болохуйц хэмжээнд байгааг хэлье. Хүмүүс төгрөгийн ханшийг хамгаалах талаар Төв банк юу ч хийхгүй байна гэж шүүмжилж байгаа. Юуны тулд Төв банк байдаг вэ гэхээр дунд, урт хугацаандаа ханш инфляцыг тогтвортой байлгахын төлөө бодлого хэрэгжүүлдэг бодлогын институц.

Тэрнээс биш өнөөдөр төгрөгийн ханш уналаа гээд улс даяараа хурааж хуримтлуулсан 3 тэрбум доллараа цацаад байвал юу үлдэх билээ. Бид энэ нөөцийг хэрхэн бүсээ чангалж, зардлаа хумиж, төсвийн хатуу бодлого барьж байж хурааж хуримтлуулсан билээ. Уул уурхайн

бүтээгдэхүүний үнэ сүүлийн нэг жилд сайн байсан учраас төсвийн орлого өндөр байна. Үүний ачаар төсвийн алдагдлаа бууруулж чадлаа гээд өдөр болгон интервенц хийгээд нөөцөө зараад байх нь зөв үү.

Төв банк шууд утгаар нь интервенц хийж нөөцөөсөө зараагүй ч макро зохистой бодлогыг маш эрчимтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авч эхэлсэн гэж бид харж байна. Мөнгөний бодлогын зөвлөл сүүлийн хоёр удаагийн хурлаараа долларын орлогогүй хэрнэ доллараар зээл авч байгаа хувь хүн, аж ахуйн нэгжийг ханшийн эрсдэлээс хамгаалахын тулд энэ төрлийн зээлийг хумих арга хэмжээ авлаа. Хэрэглээний зээл олгох хамгийн урт хугацааг 30 сар болгож богиносголоо. Эдгээр арга хэмжээг 2019 оны нэг сарын нэгнээс хэрэгжүүлнэ. Хэрвээ долларын ханш төгрөгийн эсрэг байж болохуйц хэмжээнээс хэтэрч чангарсан тохиолдолд Мөнгөний бодлогын зөвлөлийг яаралтай хуралдуулж, тодорхой арга хэмжээ авахад бэлэн гэдгээ мөн Төв банк зарласан.

Эдийн засаг өсч байгаа энэ үед Монгол Улсын Засгийн газар, төр хэд хэдэн зүйл дээр анхаарахыг Дэлхийн банк зөвлөсөн. Тухайлбал, мөнгө угаахын эсрэг олон улсын үүрэг даалгаврыг авч хэрэгжүүлэхэд анхаарах, ядуу эмзэг иргэдээ хамгаалахыг онцлон зөвлөлөө. Энэ чиглэлээр ахиц гараагүй гэж үзсэн хэрэг үү?

-Олон улсын татварын байгууллага, мөнгө угаах болон

терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ОУ-ын байгууллагын зүгээс МУ энэ чиглэлээр дорвитой арга хэмжээ авахгүй байгаагаас саарал жагсаалтад оруулахыг анхааруулж байсан. Үүнийг засахын тулд МУ-н Засгийн газар, Төв банкнаас тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байна гэж бид үзэж байгаа. Тиймээс хэд хоногийн өмнө Европийн ОУ-ын татварын байгууллага МУ-ын ЗГ-аас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг сайшааж, Монгол Улсыг саарал жагсаалтад оруулахыг хойшлуулж, үр дүнг нь харахаар болсон. Хэрвээ бид мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээгээ идэвхжүүлэхгүй бол эдийн засгаа тэлэх, хөрөнгө оруулагч татах ажил ямар ч үр дүнгүй болно.

Мөн Дэлхийн банк ядуу эмзэг бүлгийн нийгмийн халамжид анхаарахыг энэ удаагийн тайландаа онцолсон учир нь ханшийн савалгаа үүсэх, инфляц өсөх зэрэг үед хамгийн түрүүн ядуу эмзэг бүлэг, доогуур орлоготой хүмүүс өртдөг. Тийм учраас ганц Монгол биш бусад улс орнуудад санхүү, мөнгөний бодлогоо авч хэрэгжүүлэхдээ ядуу эмзэг бүлгийнхэнд тусах үр нөлөөг бага байлгах, тэднийг эрсдэл үү орохоос сэргийлэх бодлогыг давхар авч явах хэрэгтэйг зөвлөж байна. 2017 оны албан ёсны тайланд МУ-ын нийт хүн амын 29 хувь ядуу эмзэг байсан. Тийм учраас Дэлхийн банк ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд төсвийн зээл олгохдоо эмзэг бүлэг, доогуур орлоготой иргэд рүү

чиглэсэн нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг өмнөх онуудаас бууруулахгүй байх нөхцлийг Засгийн газарт тавьсан.

Мөн Дэлхийн банк өрийг бууруулах бодлогоо үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт зөвлөлөө. Гэтэл нөгөө талд өрийг өрөөр дарсан хэвээр байхад эерэг үзүүлэлт гарахгүй гэж үзэх нь ч бий.

Эдийн засгаа сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлж, ОУ-ын байгууллагуудтай хамтраад хатуу чанга бодлого явуулж байгаагийн хамгийн гол зорилго нь МУ-ын дархлааг сайжруулах явдал. Өөрөөр хэлбэл ахиухан нөөцтэй, өр багатай байх гэсэн үг. МУ-ын өр 2016 оны эцэст ДНБ-ний 87 хувьтай тэнцэж байлаа. Түүнээс хойш төсөв мөнгө, санхүүгийн хатуу бодлого авч хэрэгжүүлсний дүнд 2017 онд 84 хувьтай тэнцсэн. Энэ онд 74 хувь болж буурах төлөвтэй байна. Тиймээс ирэх 2019 онд ДНБ-тэй харьцах өрийн хэмжээг 71 хувь руу оруулж буулгах зорилт тавьж байгаа юм билээ. Дэлхийн банк үүнийг заавал тавигдах ёстой шаардлага гэж үзэж байна. Төсвийн байдал бидний тооцоолсноос илүү сайжирч байна. Тиймээс өмнө нь 2012, 2013 онд авсан, өндөр өртөгтэй, арилжааны нөхцөлтэй зээлүүдийг төлж байна. Аль болох өртөг багатай зээлээр дарж байна гэсэн үг. Хэдийгээр зээлийг зээлээр дарж байгаа ч асар өндөр ялгаатай. Жилийн 9 хүртэл хувийн хүүтэй, хэдхэн жилд төлөх зээлүүдийг 30-40 жилийн,

жилийн 0.75-1 хувийн хүүтэй зээлээр төлж байгаа нь асар их ялгаатай. Ийм ч учраас Монголд өрийн дарамт нэлээн сайн буурч байгаа гэж үзээд энэ бодлогоосоо ухарч няцахгүй, сонгууль дөхсөн ч өмнөх амлалтаасаа буцахгүй тууштай хэрэгжүүлэх байх аа гэж Дэлхийн банк найдаж байна.

2019 оны Монгол Улсын төсвийн төслийг УИХ хэлэлцэж, баталлаа. Ирэх онд цалин тэтгэврийг чамгүй хувиар нэмэх нь гэсэн хүлээлт олны дунд бий. Ийм боломж хэр гэж харж байна вэ?

-Засгийн газар ирэх онд байгаа хэр хэмжээндээ тааруулж цалин аль болох нэмэх чиглэл барьж байгаа юм билээ. Тодорхой төсөв суулгасан байсан. Нөгөө талд бид өнгөрсөн жилүүдэд ийм их хүчин чармайлт гаргачаад эргээд үр дүнгээ салхинд хийсгэмээргүй байна. Цалин нэмлээ л бол инфляц өснө. Ямар ч үр дүнгүй гэсэн үг. Тиймээс өнөөдрийнхөө төсвийн нөхцөл байдалд тохируулж цалин орлогыг өсгөх хэрэгтэй гэж зөвлөж байна.

Гадаад орчин улам бүр тодорхой бус болж байгааг Дэлхийн банк энэ удаагийнхаа тайланд анхааруулж мэдээлсэн. Зарим мэдээллээс харахад түүхий эдийн үнэ саарч, МУ бас л хүндхэн нөхцөл байдалтай тулж магадгүй нь гэж харагдаж байна.

АНУ-ын зүгээс мөнгөний бодлогоо хатууруулж байна. Долларын ханш үргэлжлэн чангарч, дэлхийн бүх оронд энэ нь нөлөөлнө гэсэн үг. Дэлхийн маш

олон орнуудын дотоодын мөнгөн тэмдэгтүүдийн эсрэг чангараад эхэлсэн. Дараагийн нэг эрсдэл нь дэлхийн зах зээлд газрын тосны үнэ нэмэгдэх хандлагатай боллоо. Энэ нөхцөлд түүхий эдийн үнэ унаж болзошгүй. Зэс, нүүрсний үнэнд нөлөөлнө гэсэн үг.

Мөн Хятад улсын эдийн засаг үргэлжлэн суларна. Хятадын эдийн засгийн өсөлт 4-5 жилийн өмнө 11, 12 хувьтай байсан бол өнөөдөр 6-6.5 хувьд хэлбэлзэж байна. Энэ онд 6.5 хувь, ирэх онд 6.2 хувьтай байх болов уу гэсэн эхний таамаг гарсан. Ирэх онд худалдааны болон тарифын шалтгаантай зөрчилдөөн, хоригийн нөлөө Хятад улсын эдийн засагт яаж тусахыг тооцоолсны үндсэн дээр бодит дүр зураг гарч ирнэ.


ОУВС -ийн хөтөлбөрийг Монгол Улс хэрхэн хэрэгжүүлж байна гэж Дэлхийн банк үзэж байгаа вэ?

-Монгол Улсын Засгийн газар ОУВС-тай тохирсон макро хөтөлбөрөө маш сайн хэрэгжүүлж байгаа. 2017 онд гадаад зах зээл сайн байсан, түүхий эдийн үнэ ханш сэргэсний ачаар зарим үзүүлэлтээ давуулан биелүүлсэн. Тавьсан шаардлагаас илүү өндөр орлого олсон. ОУ-ын байгууллагууд ч МУ сайн биелүүлж байгаа гэж дүгнэж буй. Гол нь ОУВС-ийн хөтөлбөр 2020 он хүртэл хэрэгжинэ. Энэ хугацааг дуустал амлалтдаа хүрч төсөв, мөнгөний бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь чухал байна. Учир нь УИХ-ын сонгууль дөхөх үед

төсвийн зардлыг нэмдэг, үргүй зардлаа өсгөдөг. Болсон болоогүй нэг удаагийн амлалт өгч, түүнийгээ төсвөөс санхүүжүүлдэг. Шалтаг, шалтгаангүй цалин тэтгэвэр нэмдэг, нэмэх амлалт өгдөг гээд асуудлууд бий. Ийм алдааг битгий давтайсай. Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн чанга бодлогоо тэр хэлбэрээр нь үргэлжлүүлэн хэрэгжүүлээсэй гэж хүсч байна.

Та Дэлхийн банкны Монголыг хариуцсан эдийн засагчаар 2000 оноос хойш ажиллаж байна. Туршлагаасаа харсан ч таны хэлсэн шиг төсвийн чанга бодлого сонгуулийн жилүүдэд хэрэгжихэд хүндхэн болов уу?

-Би 2000 оноос эхлээд бүхий л сонгуулийг үзлээ. Бүхий л ЗГ, Төв банк, Сангийн яамтай ажиллалаа. Бидний ажиглахгүй байгаа нэг зүйл бол Монголын ард түмэн маш их юм үзэж нүд тайлсан. 2000 онтой харьцуулахын аргагүй болсон. Гадаад дотоод ертөнцөд юу болж байна, бид хаана нь байна гээд монголчуудын үзэл бодол сууриараа өөрчлөгдсөн. Тиймээс 2020 оны сонгуулийн өмнө өмнөх жилүүдийнх шиг байдлууд давтагдахгүй байх аа гэж найдаж байна. Улс төрийн төвшинд тодорхой хандлага гарч болзошгүй ч түүнээс урьдчилан сэргийлэх маш хүчтэй шүүмжлэл доороосоо, олон нийтээс гарч байгааг анхаарч үзэхгүй байхын аргагүй. Тиймээс 2020 онд утга учиргүй амлалтууд гарахгүй байх. Төсвийг хий хоосон зарахгүй байх гэж найдаж байна.



ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТӨД ТЕХНОЛОГИ БОЛОН УУР АМЬСГАЛЫН НӨЛӨӨ

Нобелийн нэрэмжит шагнал гардуулах үйл ажиллагааны хүрээнд эдийн засгийн салбарт чухал нээлт хийсэн эрдэмтэн судлаач нарыг Шведийн төв банкны санаачлага болон хандиваар жил болгон шалгаруулж шагнал гардуулдаг билээ. 1969 оноос 2018 оны хооронд 50 удаа эдийн засаг дахь Нобелийн шагналыг нийт 81 хүнд гардуулаад байна. “Монголбанкны мэдээлэл” товхимлын ээлжит дугаарын олон улсын эдийн засаг булангаар 2018 онд Нобелийн шагналыг эдийн засгийн салбарт хүртсэн Виллиам Д. Нордхаус болон Пол М. Ромер нарын талаар болон тэдний судалгааны ач холбогдлыг танилцуулж байна.

Хязгаарлагдмал нөөцийг удирдах

Эдийн засгийн ухааны суурь зарчим бол хязгаарлагдмал нөөцийг зүй зохистой удирдаж, хэрэгцээг хангах замаар өсөлтийг бий болгох явдал билээ. Нөгөө талаас эдийн засгийн өсөлтөд нөөцийн хязгаарлагдмал байдал хазаар болдог учраас энэхүү хязгаарлагдмал байдлыг зүй зохистой ашиглахад олон зүйлсийг харгалзаж үзэх шаардлагатай. Урд нь эдийн засгийн сурах бичгийг нээж үзэхэд инфляци,



ажилгүйдлийн түвшин гэх мэт богино хугацааны бизнесийн мөчлөгийн ойлголтуудын илүүтэйгээр тайлбарладаг байсан. Харин 2018 оны Нобелийн шагналтнууд нь урт хугацааны эдийн засагт байгаль орчин болон мэдлэгийн нөлөөллийг судалж, бие даасан загварчлал боловсруулснаараа эдийн засгийн судалгаа шинжилгээ, сурах бичигт өөрчлөлт оруулсан гавъяатай. Өөрөөр хэлбэл Паул Ромер болон Виллиам Нордхаус нар нь эдийн засгийн өсөлтийн онолын салбарт дэвшил авчирсан.

Технологийн дэвшил

Эдийн засгийн өсөлт зарим улсад тогтвортой байдаг бол заримд нь тиймгүй аж. Урт хугацаанд тогтвортой өсөлтийг хангагч хүчин зүйлийг эдийн засагчид дуу нэгтэйгээр технологийн дэвшил гэж зөвшөөрдөг ч яаж болон хэрхэн гэдгийг Ромерийн судалгаа тайлбарлаж чадсан. Аж үйлдвэрийн хувьсгалаас өмнө эдийн засгийн тогтвортой өсөлт гэж хэлэгдэх зүйл байгаагүй. Харин технологийн хувьсгал гарснаар өсөлтийг тэтгэж эхэлсэн байдаг. Ромер технологи буюу урт хугацааны эрүүл өсөлтийн урь

тал нөхцөлийг мэдлэгтэй холбон тайлбарласан. Мэдлэг гэдэг нь өөрөө инноваци, шинэ санааны салшгүй хэсэг бөгөөд Ромер 1990 онд хэвлүүлсэн ажилдаа “эндоген өсөлтийн онол”-ын суурийг тавилцсан. Тус онолд эдийн засгийн өсөлт нь гадаад гэхээс илүү дотоод хүчин зүйлсээр өдөөгддөг хэмээн номлодог. Тэдгээр дотоод хүчин зүйлс бол технологи + капитал + ажиллах хүч бөгөөд эдгээрт амжилттай хөрөнгө оруулалт хийснээр өсөлтийг өдөөх боломжтой.



АНУ-ын эдийн засагч, Нью Йоркийн их сургуулийн профессор Ромер нь онолын тал дээр ч, бодит зах зээлийн тал дээр ч ихээхэн судалгаа хийдэг байсны хувьд түүний судалгаа нь дан ганц онолын салбарт бус мөн бодит амьдрал дээр амжилттай биелдэг. Тэрбээр зарим санаанууд яагаад амжилт олдог, зарим нь яагаад амжилтгүй үлддэг вэ гэдгийг судалж өдгөө бодлого

тодорхойлогч нарт чухал зөвлөмж болж байгаа. Шинэ санаа дан нэг төрлийн зах зээл дээр бус мөн бусад төрлийн зах зээлд амжилт олохын тулд оюуны өмчийг хамгаалах, патентжуулах гэх мэт хууль эрх зүйн зохицуулалт хийх замаар дэвшилтэт санааг сэдээж байх хэрэгтэй. Өнөөгийн инноваци бүхий бүтээгдэхүүнүүдийг бий болгох санаа нь ихэнхдээ өөр улсын, хэн нэгний санаанаас урган гарсан байдаг гэхэд хилсдэхгүй. Тиймээс нэг талаар технологийн дэвшлийг өөртөө агуулсан шинэ санааг хамгаалахын хажуугаар хэтэрхий их боож, хязгаарлалт хийхгүй байх нь чухал. Ингэснээр эдийн засгийг урт хугацаанд тэтгэгч шинэ инновацилаг бүтээгдэхүүнүүд бий болдог.

Пол Ромер эдийн засгийн нийтлэл тогтмол бичдэг бөгөөд олон нийтэд <https://paulromer.net/> веб хуудсаараа дамжуулж хүргэдэг.

Уур амьсгалын өөрчлөлт

Нордхаусын хувьд түүний судалгаанууд нь байгалийн ухаан болон нийгмийн ухааны уулзвар дээр хийгдсэн байдаг. Тэрбээр 1970-аад оноос уур амьсгалын өөрчлөлт буюу физик, химийн шинжлэх ухааныг эдийн засгийн ухаантай холбож судалж эхэлсэн. Өдгөө энэ нь ихээхэн хурцадмал асуудал болоод байгаа ч тухайн үед эдийн засагчдын төдий л анхаардаггүй сэдэв байв. Мөн нөгөө талаас сүүлийн үед эдийн засгийн ухааныг бусад салбарын

шинжлэх ухаануудтай хослуулж судалдаг болоод байгаа бол 1970-аад онд зөвхөн математикийн ухаантай л холбодог байсан.



Йелийн их сургуулийн Стерлингийн профессор Нордхаус нь Бостон дахь Холбооны нөөцийн банкны захирлуудын зөвлөлийн даргаар ажиллаж байсан нэгэн. Тэрбээр эдийн засагч ч гэлээ байгалийн ухааныг шамдан судалсны үр дүнд 1990-ээд онд “нэгдсэн үнэлгээний загвар”-ыг анх удаа боловсруулсан. Энэ нь уур амьсгалын өөрчлөлт нь дэлхийн эдийн засагт хэрхэн нөлөөлдөг талаарх тооцоолол хийдэг математик загварчлал юм. Тухайлбал хүлэмжийн хий хэр их нэмэгдэхэд, агаарын дундаж температур 1°C өсөх, мөн энэ нь улс орнуудын бүтээмж, өрсөлдөх чадвар, ард иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх талаар тооцоолно гэсэн үг. Нарийн тооцоолол бүхий үр дүн гаргах боломжтой учраас Нордхаусын загвар нь хүлэмжийн хийн татвар зэрэг уур амьсгалын бодлогыг тодорхойлоход өргөнөөр ашиглагдаж байна.

Мэдээж уур амьсгалын өөрчлөлт нь маш өргөн хүрээг хамарсан асуудал. Улс орнуудын эдийн засаг цаашид

хэрхэн хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсч болох вэ гэсэн асуулт нь уур амьсгалын өөрчлөлттэй шууд холбогдож байгаа. БНХАУ-ын жишээ нь дээр авч үзэхэд, тус орны хөгжлийн бодлого нь нүүрсний түлшнээс байгалийн хийн түлш рүү шилжиж байна. Учир нь нүүрсээр эрчим хүч, дулаанаа хангахад хэмнэсэн багахан зардал нь эргээд агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлийг эмчлэх эрүүл мэндийн зардлыг хэд дахин үржүүлж байгаа аж. Мөн уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал нь цөлжилт, хуурайшилтыг хурдасгаж улмаар газар тариалан, мал аж ахуй гээд дэлхийн эдийн засгийн чухал салбаруудын бүтээмжийг бууруулж байгааг анхаарах хэрэгтэй.

Энэ оны Нобелийн шагналыг эдийн засгийн салбарт хүртсэн эрхмүүд нь тогтвортой бөгөөд хүртээмжтэй өсөлтийн эцсийн жорыг бий болгож хараахан чадаагүй ч гэлээ түүнийг бий болгох хүчин зүйлсийг тодорхойлоход нөр их судалгааны ажил хийж, урд нь хариулж чаддаггүй байсан чухал асуултуудын хариултыг олж өгсөн.

Эцэст нь тэмдэглэж хэлэхэд Монголбанкнаас “Улаанбаатарын зөвшилцөл” буюу эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг бий болгох санаачлагыг гаргасан ба Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг урт хугацаанд тогтвортой хадгалахын тулд 8 зарчмыг санал болгоод байгаа.

ОНБМТ-ийн ахлах эдийн засагч Н.Батжин

Эх сурвалж: <https://www.nobelprize.org/uploads/2018/10/press-economicsciences2018.pdf>

ИРЭЭДҮЙДЭЭ ЗОРИУЛЖ ХУРИМТЛУУЛАХ НЬ

Хуримтлал үүсгэх нь танд болон танай гэр бүлд тохиож болох гэнэтийн үйл явдлаас үүсэх санхүүгийн хүндрэлийг даван гарахад тус болохоос гадна ирээдүйд гарах зардлуудыг (сургалтын зардал, бэлэг дурсгал, амралт, гэр орны ахуйн хэрэгцээ) төлөх боломжийг олгоно. Байнгын хуримтлалтай байх нь зээл авах

шаардлага гарсан тохиолдолд бага хэмжээгээр авах боломжийг олгох ба нэмэлт орлогын эх үүсвэрийг бий болгож өөрийн санхүүгийн байдалдаа санаа амар байх баталгааг өгөх юм. Та хуримтлуулж эхлэхээсээ өмнө өмнө нь авсан байсан зээлээ төлж барагдуулахаа мартуузай.

3 сар хэрэглэнэ гэж тооцоолох хэрэгтэй. Жишээ нь: Хэрэв та сард 1,000,000₮ зарцуулдаг бол таны гэнэтийн осолд хэрэглэх хуримтлал дор хаяж 3,000,000₮ байх ёстой. Яг одооноос хуримтлуулах боломжгүй бол санаа зовох зүйлгүй ба зорилгодоо хүрэх төлөвлөгөөгөө боловсруулаарай.

Жишээ:

ХЭРХЭН АВТОМАШИНТАЙ БОЛОХ ВЭ?	
Одоо зээлэх үү? Тэмүүлэн 2192369 төгрөгийн хадгаламжаар урьдчилгаа төлбөрөө төлөөд 10.0 сая төгрөгийн үнэтэй автомашин худалдан авахад зээлийн төлбөрт сард 716447 төгрөг төлөхөөр байна. Сул тал 1 жилийн хугацаанд зээлийн хүүнд 777148 төгрөг төлөх ба зээл авахтай холбоотой нэмэлт зардлууд гарна Давуу тал Яг одоо автомашинтай болох боломжтой.	Нэг жилийн өмнөөс хуримтлуулах уу ? Харин одоо зээл авахгүйгээр 2192369 төгрөгөө үргэлжлүүлэн 1 жил хадгалахдаа зээлийн төлбөрт төлөх байсан дүнтэй ойролцоо буюу 650000 төгрөгийг сар бүр нэмж хийхэд 1 жилийн дотор зээлгүйгээр 10.0 сая төгрөгийн автомашинаа авах боломжтой. Давуу тал Харин эсрэгээрээ банк 882414 төгрөгийн хүү таны хадгаламжид төлөхөөр байна. Сул тал 1 жилийн дараа автомашинаа авна.

Гэнэтийн үйл явдалд зориулсан хуримтлалаа зөвхөн гэнэтийн үйл явдалд тохиосон үед л хэрэглээрэй. Хэрэв энэхүү хуримтлалаасаа мөнгө авах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд богино хугацаанд эргүүлэн олж, авсан мөнгөө буцааж хуримтлалдаа хийх нь хамгийн чухал.

Хуримтлуулах мөнгөний хэмжээгээ тооцоолон, зорилго тавин түүндээ хүрэхийн тулд төлөвлөгөө гаргах нь чухал. Дараа нь 7 хоногт эсвэл 1 сард хэдий хэмжээний мөнгө хуримтлалдаа хийх боломжтойгоо тодорхойлохоос гадна, хэдий хугацаанд энэхүү хуримтлалаа хуримтлуулах вэ гэдгээ төлөвлөөрэй.

Ирээдүйдээ зориулж хуримтлуулж эхлэхдээ та хамгийн түрүүнд гэнэтийн ослоос өөрийгөө хамгаалахад зориулан хуримтлал үүсгэж эхлээрэй. Жишээ нь:

эмнэлгийн зардал, ажлаас гэнэт халагдан, дараагийн ажлыг олох хүртлээ зарцуулах зардал гэх мэт. Гэнэтийн зардлуудад хэрэглэх хадгаламжийг дор хаяж

ХУГАЦААГҮЙ ХАДГАЛАМЖ

Та мөнгөө богино хугацаанд ашиглахаар төсөвлөсөн эсвэл гэнэтийн зардалд зарцуулахаар төлөвлөсөн бол хугацаагүй хадгаламжийг сонговол ашигтай.

Харилцах данс

Өдөр тутмын төлбөр тооцоо төлөхөд ашиглах хүүгүй эсвэл маш бага хүүтэй байдаг.

Хугацаагүй хадгаламж

Харилцах данстай ижил боловч хүүний хувьд өндөр байдаг. Жишээлбэл банкууд жилийн 6% хүртэл хүү санал болгож байгаа гэж авч үзвэл хүүний төлбөрийг жил бүрийн сүүлийн өдөр дансанд шилжүүлнэ. Нэг сул тал нь банк хадгаламжийн хүүгээ бууруулахад таны хадгаламжийн хүү буурна. Харин давуу тал нь банкны хүү нэмэгдвэл таны хүү мөн нэмэгдэнэ.

ХУГАЦААТАЙ ХАДГАЛАМЖ

Та тодорхой зорилготойгоор хуримтлуулах, мөнгөний хэрэгцээгээ хугацааны хувьд төлөвлөх боломжтой бол хугацаатай хадгаламжийг сонговол ашигтай.

Тодорхой хугацаатай хадгаламж

1,3,6,12 сар болон түүнээс дээш хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүн банкууд санал болгодог. Энэ нь хугацаагүй хадгаламжтай харьцуулахад өндөр хүүтэй байдаг. Та нэмэлт хуримтлал хийх боломжтой. Хэрвээ танд гэнэтийн мөнгөний хэрэгцээ хадгаламжийн хугацаа дуусахаас өмнө гарвал та хугацаагүй хадгаламжаас ч бага хүү авна. Иймээс таны санхүүгийн төлөвлөлт чухал юм.

Хадгаламжийн сертификат

Энэ нь хугацаатай хадгаламжаас өндөр хүү төлдөг хатуу нөхцөлтэй бүтээгдэхүүний нэг юм. Өөрөөр хэлбэл, хадгаламжийн хугацааны дундуур орлого хийх ба хугацаанаас өмнө цуцлах боломжгүй байдаг. Харин мөнгөний хэрэгцээ гарсан бол бусдад шилжүүлэх, зарах, бэлэглэх замаар бэлэн мөнгө болгож болдог.

Хуримтлалын зорилго

Ирээдүйгхэн ч урьдчилан харж чадахгүй учраас санхүүгийн хувьд хүчтэй, өөртөө итгэлтэй, төлөвлөгөөтэй амьдрах нь аз жаргалтай амьдралын үндэс.



Жишээ нь: Та 900,000 төгрөгийн үнэтэй компьютер авахаар төлөвлөсөн гэж бодъё. Та сар бүр 100,000₮ хуримтлуулснаар 9 сарын дараа компьютерээ авах аль эсвэл 50,000₮ хуримтлуулснаар 20 сарын дараа авч болох юм. Та сард хэдий хэмжээний мөнгө хуримтлуулах боломжтой болон хэдий хугацааны дараа компьютерээ худалдан авахыг хүсэж байна вэ гэдгийг хооронд нь уялдуулан тооцооллоо хийх нь зүйтэй.

Хэдий хэмжээний мөнгө сар бүр хуримтлалдаа нэмэх вэ гэдгийг тодорхойлохын тулд төсөв хөтлөх хэрэгтэй. Төсөв гэдэг нь таны орлого, зарлага, хуримтлалыг хэлнэ.

Хэрэв танд хуримтлалаа хадгалахад хэцүү, үе үе

хуримтлалын мөнгөнөөсөө зарцуулаад байгаа бол зардлаа багасгах боломж байна уу, үгүй юу гэдгийг эргэн нэг хараарай. Зардлаа багасгаж чадсанаар танд илүү ихийг хуримтлуулах боломж үүснэ гэдгийг битгий мартаарай.

Хуримтлалтай болох алхам



Гэр бүл, найз нөхдөдөө өөрийн хуримтлалын талаар хэлэх нь эргээд тэд танд хуримтлалаа өсгөх мотивацийг өгөх болно.

Санамж: Хэдий эрт хуримтлуулж эхэлнэ, төдий чинээ өөрийн урдаа тавьсан зорилгодоо хүрэх болно.

Эх сурвалж: www.sankhuuginbolovsrol.mn

ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлсэнээс хойш 2018/10/30-ний хооронд 518.7 сая ам.долларын болон 110.4 сая юанийн нийт 864 удаагийн арилжаа Банк хоорондын валют арилжааны цахим талбарт хийгдээд байна.




График 1. 1990-2018 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ

Монголбанкны алт худалдан авах үнэ (төгрөг/грамм)




График 2. 2018 оны 10 дугаар сард Монголбанкны алт худалдан авсан үнэ



АЯНЫГ ДЭМЖИГЧ

PSM)))

PROJECT

ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН
ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ

ЦАХИМ ЭРИНД ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦОО АЯН

2018.10.10-12.10



www.mongolbank.mn



[@mongolbank.mn](https://twitter.com/mongolbank.mn)



[Mongolbank.mn](https://www.facebook.com/Mongolbank.mn)



[Mongolbankmn](https://www.youtube.com/Mongolbankmn)